



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



ЭРҮҮЛ **ҮНДЭСНИЙ** МОНГОЛ ХҮН **ХӨДӨЛГӨӨН**





ИН
ЛИЙН
ТАМГЫН ГАЗАР



ЭРХЛЭН ГАРГАСАН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН
“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ТЭСЭЛ, ХӨТӨЛБӨР ХАРИУЦСАН АЛБА

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИЛГЭЭЛТ

2

НЭГ

- 1.1. “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН БОЛ СУДАЛГААНД СУУРИЛСАН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ИНТЕРВЕНЦ ЮМ
- 1.2. МЭНДЧИЛГЭЭ:
 - Засгийн газрын төлөөлөл
 - Олон улсын байгууллагын төлөөлөл

ХОЁР


- “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН 12
- 2.0. ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН
- 2.1. ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН
- 2.2. ЭРҮҮЛ ЗАН ҮЙЛ
- 2.3. ЭРҮҮЛ ОРЧИН БА ЗӨВ ХООЛЛОЛТ
- 2.4. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ 36

ГУРАВ

- **УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ 38**
- 3.1. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА
- 3.2. УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ 50

ДӨРӨВ

- **“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН БА ХЭРЭГГИЖ БҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА 51**
- 4.1. Баянхонгор аймагт нээлттэй өдөрлөг зохион байгуулагдлаа 39
- 4.2. “Эрүүл Монгол хүн” Налайх дүүрэгт 45
- 4.3. Намайг алгас нөлөөллийн аян зохион байгуулагдлаа 48
- 4.4. “Цаг гаргая” аян 50
- 4.5. Сар шинэ – зохистой хооллолт
- 4.6. Судалгаа





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИЛГЭЭЛТ

Эрхэм уншигч танд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Дэлхий дахин халдварт цар тахал өвчний эрсдэлийг бууруулах, тээвэр ложистик, цэрэг дайны зэрэг томоохон сорилтуудтай нүүр тулж буй хүндхэн цаг үед ч хүн төрөлхтний орших, эс оршихуйн нэгэн гол шалтгаан болсон хүн амын эрүүл мэнд, байгаль экологи, хүнсний аюулгүй байдлын асуудлыг хойш тавьж болохгүй юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь хүн төвтэй аюулгүй байдлын зарчимд тулгуурладаг бөгөөд зуун жилийн дотор Монгол Улсын хүн ам 5,6 дахин өсөж, 600 орчим мянгаас 3.4 саяд хүрсэн нь өнгөрсөн зууны шинжлэх ухаан, технологийн ололт амжилтаас гадна эрүүл мэндийн салбарын болон ард иргэдийн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллаж, хөдөлмөрлөсөн үе үеийн албан хаагчдын нэр их хөдөлмөрийн бодит үр дүн бөгөөд ирээдүйн 20 жилд энэ тоо 5.0 саяд хүрч нэмэгдэх төлөвтэй байна. Иймд ирээдүй хойч үеэ эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх нь өнөөдрийн бидний үүрэг, хариуцлага мөн.

Хөрс, хүнс, хүн гурав хүйн холбоотой. Хөрс эрүүл бол хүнс эрүүл, хүнс эрүүл бол хүн эрүүл байна. Иймээс төрийн тэргүүний хувиар өөр хоорондоо нягт уялдаа холбоотой “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг санаачлан экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хүнсний аюулгүй байдлыг хангах, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр холбогдох зарлиг шийдвэрийг гарган хэрэгжүүлж эхлээд байна.



Хөрс эрүүл бол хүнс эрүүл, хүнс эрүүл бол хүн эрүүл байна.

Эрхэм уншигчид аа!

Эх дэлхий, байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, сөрөг нөлөөллийг бууруулах, ойн хомсдол, доройтлыг багасгах, усны нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1.5 тэрбум мод тарьж ургуулан ойн санг 9.0 хувьд хүргэж, цөлжилт, газрын доройтолд нэн хүчтэй өртсөн газар нутгийг 4 хувиар бууруулж, ойн сангийн хүлэмжийн хийн шингээлтийг 11 хувиар нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Тус хөдөлгөөнийг өрнүүлж эхэлснээс хойш 39 төрлийн модлог ургамлын 12.1 тонн үрийн нөөцийг бүрдүүлсэн нь өмнөх үеэс 4.5 дахин нэмэгдэж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 306 мод үржүүлгийн газарт 45.8 сая тарьц, суулгацыг бэлтгэж, 2021-2022 оны намар, хаврын улиралд улсын хэмжээнд 10.2 сая мод тарьж ургуулаад байна. Энэ нь байгалиа бүтээн нөхөн сэргээж, эх нутгийнхаа онгон дагшин газар нутгийг хойч ирээдүйд өвлүүлэн үлдээх, Монгол хүн эрүүл, таатай, аюулгүй орчинд амьдрахад томоохон түүхэн эхлэл, байгалийн өв сан болно гэдэгт итгэлтэй байна.

Түүнчлэн хүний эрүүл мэнд нь идэж буй хоол хүнсний аюулгүй байдал, хүртээмж, хангамж, чанараас шууд хамаардаг. Иймээс үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн Эрүүл зөв нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэх, Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын

үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авна хэмээн тусгасан. Хүнээ хамгаалъя, хүнээ хөгжүүлъя гэвэл хүнсээ сайжруулах ёстой. Тиймээс эрүүл, аюулгүй, хүний бие махбодын хэрэгцээнд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангахад чухал үүрэг, оролцоотой Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж байна.

Бидний өвөг дээдэс өнө эртнээс нүүдлийн мал аж ахуй эрхэлж хоол хүнс, дээл хувцас, эд зүйлсээ өөрсдөө үйлдвэрлэж, худалдаа наймаа эрхэлж, бусдаас хараат бус оршин тогтнож ирсэн олон зуун жилийн түүхтэй. Өнөөдөр манай улс хүнсний бүтээгдэхүүнийхээ 50 орчим хувийг тухайлбал, хүнсний ногоо, сүүн бүтээгдэхүүний 40 орчим, өндөгний 50 орчим, будаа, элсэн чихэр, давсаа 100 хувь гаднаас авч байна. Иймээс бид ирэх таван жилд гол нэрийн 19 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж хүнсний хувьсгал хийцгээе. Эрүүл хүнс тухайлбал, эрүүл шимт малын сүү, сүүн бүтээгдэхүүн, эх орны эрүүл хөрсөнд ургасан хүнсний ногоо, жимс жимсгэнэ, гурил, гурилан бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангаж, иргэд нь зөв Эрүүл зөв хооллолтыг эрхэмлэн Эрүүл Монгол болцгооё.

Монгол хүн эрүүл байвал Монгол үндэстэн хүчирхэг байна. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь эрүүл орчин – эрүүл хүнс – эрүүл хүн гэсэн харилцан уялдаатай байгаль экологийн загварт тулгуурласан хөтөлбөр юм. Энэ загвар нь эрүүл, аюулгүй байгаль орчныг бүтээж эрүүл, шимт хүнсний хэрэглээг дэмжих нийтийн эрүүл мэндийн арга хэмжээ юм.

Өнөөдрийн байдлаар эрүүл мэндийн салбарт дарамт болж буй эрүүл мэндийн тэргүүлэх





Жаргалан, жаргалан, жаргалан
Энэ ертөнцийн түмэн жаргалан
Түүний доторх чухам жаргалан
Эрүүл энхийн нэгэн жаргалан
Д.Нацагдорж

эрсдэлд зохисгүй хооллолт, архи тамхины хортой хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, түүнээс үүдсэн илүүдэл жин, таргалалт, артерийн даралт ихсэлт давамгайлж байна. Эдгээр шалтгааны улмаас үүссэн өвчнийг оношлох, эмчлэхэд эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн дийлэнх хувийг зарцуулж байна. Судалгаанаас харахад хүн амын ердөө 3.9 орчим хувь нь л саяны дурдсан эрсдэлгүй, эрүүл байна. Иймээс бид хүн амыг соён гэгээрүүлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл орчин, эрүүл хүнсээр хангах буюу өвчилсөн дараа биш, харин түүнд хүргэдэг, нөлөөлдөг эрсдэлийг мэддэг, түүнээс сэргийлдэг, эрүүл ирээдүйг бий болгохын төлөө “Эрүүл Монгол хүн” хөдөлгөөнийг эхлүүлсэн.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь хүн амын эрүүл мэндийг дэмжих, амьдралын зөв дадал, хэвшилтэй иргэн, эрүүл ирээдүйг бий болгохын тулд хүн амын бүлгүүд, тэдний нас, бие бялдрын онцлогт тохирсон нийтийн эрүүл мэндийн интервенц бөгөөд үүнийг салбаруудын уялдаа, иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх юм. Эрүүл зан үйл, амьдралын зөв дадлыг төлөвшүүлэхийн тулд бүх шатны боловсролын байгууллага онцгой анхаарч эрүүл иргэн, эрүүл ирээдүйг бий болгохын тулд хөтөлбөрийн шинэчлэл хийх, сургалтын агуулга, сургах арга барилыг оновчтой болгох нь чухал байна.

Дэлхийн улс орнуудын сайн туршлагаас харахад согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлахад хамгийн түрүүнд татварын зөв

бодлого, үнийн өөрчлөлт, тодорхой сегментэд чиглэсэн интервенц үр дүнгээ өгдөг. Иймд бид архинд ногдуулах Онцгой албан татварын тооцоолол, түүний эрүүл мэнд, эдийн засгийн үр нөлөөг олон хувилбараар тооцож, түүнд тулгуурлан холбогдох зарлиг шийдвэрийг гаргасны дагуу Улсын их хурал, Засгийн газар шуурхай ажиллан “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийг 20 жилийн дараа шинэчлэн баталлаа. Үүнтэй уялдан дагалдах хуулиудад томоохон өөрчлөлт орж, 2023 оноос согтууруулах ундааны градусаас хамааран онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлэх, литр тутмын борлуулалтын орлогын тодорхой хувийг Эрүүл мэндийн боловсрол олгох, Нийгмийн эрүүл мэндийн тусламжид зарцуулах бие даасан сан байгуулахаар дагалдах хуулиудад өөрчлөлт орлоо.

Эрхэм уншигчид аа!

Эрүүл Монгол хүн эх орны баялаг, тусгаар тогтнолын баталгаа тул хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сахин хамгаалах үйл хэрэг нь засаг захиргааны бүх шатны төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудын өндөр үүрэг хариуцлага, нягт хамтын ажиллагаа, бүтээлч санаачилга, иргэн хүний амьдралын эрүүл хэв маяг, зөв дадал зуршлаас шууд хамаарна гэдгийг санаж, дээрх хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд хүн бүр хувь нэмрээ оруулахыг уриалж байна.

Мөнх тэнгэрийн хүчин дор Монгол Улс мандан бадрах болтугай

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ

■ **НЭГ** МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
САНААЧИЛСАН “ЭРҮҮЛ МОНГОЛ
ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН





“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН БОЛ СУДАЛГААНД СУУРИЛСАН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ИНТЕРВЕНЦ ЮМ

*Т.Мөнхсайхан,
Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд,
спорт, нийгмийн бодлогын зөвлөх*

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх болсон гол шалтгаан юу вэ?

Өмнө нь хэрэгжиж байсан хөтөлбөр, төслөөс юугаараа ялгаатай вэ?

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлсноор “Эрүүл мэнд гэдэг нь хүн зөвхөн өвчин эмгэггүй байх төдийгүй бие бялдар, оюун санаа, нийгмийн байдлын сайн сайхан байдлын цогц бүрдэл” хэмээн тодорхойлсон. Эндээс харахад эрүүл мэнд гэдэг нь дан ганц биеийн эрүүл мэнд биш түүнд нөлөөлдөг хүний амьдарч буй орчин, сэтгэлзүй, нийгэм, хамт олны харилцаа зэргээс хамаардаг өргөн хүрээний ойлголт.

Хүн амын дундах амбулаторид бүртгэгдсэн өвчлөл 10.000 хүн ам тутамд 8469 тохиолдол байгаагаас хоол боловсруулах, зүрх судас, амьсгал, шээс бэлгийн замын гэмтэл, хордлогын шалтгаант өвчин эхний 5 байрыг эзэлж байна

Нас баралтын шалтгаант зүрх судасны эмгэг 1990 оноос хойш тогтмол тэргүүлж байна. Тухайлбал, 1950-иад онд нас баралтын 7.1 хувь, 1995 онд 30.8 хувь, 2021 онд 31.2 хувь болж тасралтгүй нэмэгдсэн. Зүрх судасны өвчний шалтаант нас баралтын дийлэнх хувийг артерийн даралт ихсэлт, зүрхний шигдээс, тархины цус харвалт эзэлж байгаа бөгөөд үүний гол шалтгаан, эрсдэлт хүчин зүйл нь зохисгүй хооллолт буюу давс, сахар, өөх тостой хүнс, архи тамхи, хөдөлгөөний хомсдол, стресс зэрэг хувь хүний зан үйл, эрүүл мэндийн боловсролоос шалтгаалсан хүчин зүйлээс хамаардаг. Хавдрын шинэ тохиолдол, нас баралт нэмэгдэж, 1990 оноос хойш нас баралтын хоёр дахь шалтгаан болсоор байна. Нийт нас баралтын

23.1 хувийг эзэлж элэг, ходоод, гуурсан хоолой болон уушгины хавдар тэргүүлж байна. Эдгээр нь мөн хувь хүний зан үйлээс хамаардаг бөгөөд зайлсхийж болох нас баралтад тооцогддог. Хүн амын 21.9 хувийг хөдөлгөөний хомсдолтой, 49.4 хувь хүн амын илүүдэл жинтэй үүнээс эрэгтэйчүүд 48.0 харин эмэгтэйчүүдийн 50.9 хувь, таргалалт нийт хүн амын - 18.5 хувь, эрэгтэйчүүдийн 16.6 хувь, эмэгтэйчүүдийн 20.4 хувь байна

Монгол Улсын хүн амын нас баралтын 77 хувийг дээрх эрсдэлээс үүдэлтэй халдварт бус өвчин эзэлж, салбарын нийт төсвийн 70 гаруй хувийг архагшсан, хожуу шатны өвчний өртөг өндөртэй оношилгоо, эмчилгээнд зарцуулж байгаа тул өвчилсний дараа бус харин түүнд хүргэж буй эрсдэлт зан үйлийг бууруулах, соён гэгээрүүлэн эрүүл мэндийг боловсролыг дээшлүүлэх нь чухал юм.

Иймээс “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь өвчилсний дараа биш харин эдгээр эрсдэлийг бууруулах буюу хувь хүний зан үйл, амьдралын дадал зуршил, эрүүл мэндийн боловсрол, орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн Нийтийн эрүүл мэндийн арга хэмжээг хүн амын бүлгүүдийн онцлогт нийцүүлэн цогц, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэж байна. Эрүүл мэндийн салбарт нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр маш олон үндэсний хөтөлбөр, стратеги хэрэгжсэн хэдий ч дорвитой өөрчлөлт гарахгүй, хүн амын өвчлөл тасралтгүй нэмэгдэж байгаа учраас бид судалгаанд суурилан уг эмгэгт хүргэж буй эрсдэл, шалтгааныг тогтоон, түүнийг бууруулах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, иргэдийн эрүүл

мэндийн боловсролыг дээшлүүлэхэд буюу суурь болон анхдагч сэргийлэлтийг эрчимжүүлэхэд төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоонд тулгуурлан явуулахаар төлөвлөсөн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод”, “Хүнсний хувьсгал” зэрэг үндэсний хөдөлгөөнтэй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн хир уялдаж байна вэ?

Монгол хүний аюулгүй байдлыг хангах үндэс нь эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, түүний хүртээмжийг нэмэгдүүлэх явдал юм. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал нь Монгол хүн бүрийн аюулгүй байдал, эрүүл мэндээс шууд хамаарна. Хүн “Эд хөрөнгөө алдвал багыг алдана, нэр төрөө алдвал ихийг алдана, эрүүл мэндээ алдвал бүгдийг алдана” хэмээн Монголчууд бид эрүүл мэндээ эрхэмлэн дээдэлж ирсэн баялаг уламжлалтай ард түмэн. Монгол Улсын төрийн бодлогын цөм нь Монгол хүн.

Иймээс Монгол Улсын Ерөнхийлөгч хоорондоо харилцан шүтэлцээтэй “Тэрбум мод”, “Хүнсний хувьсгал”, “Эрүүл Монгол хүн” гэсэн нягт уялдаа бүхий цогц 3 үндсэн хөдөлгөөнийг санаачлан улс орон даяар хэрэгжүүлж эхлээд байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлснээр 1.5 тэрбум мод тарьж ургуулан ойн санг 9.0 хувьд хүргэж, цөлжилт, газрын доройтолд нэн хүчтэй өртсөн газар нутгийг 4 хувиар бууруулж, ойн сангийн хүлэмжийн хийн шингээлтийг 11 хувиар нэмэгдүүлнэ. Уг хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээр 2021-2022 оны намар, хаврын улиралд улсын хэмжээнд 10.2 сая мод тарьж ургуулаад байна. Энэ нь байгалиа бүтээн нөхөн сэргээж, эх нутгийнхаа онгон дагшин газар нутгийг хойч ирээдүйд өвлүүлэн үлдээх, Монгол хүн эрүүл, таатай, аюулгүй орчинд амьдрахад томоохон түүхэн эхлэл, байгалийн өв сан болно гэдэгт итгэлтэй байна. Хүний эрүүл мэнд нь идэж буй хоол хүнсний аюулгүй байдал, хүртээмж, хангамж, чанараас шууд хамаардаг. Иймээс үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн эрүүл, зөв нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэх, Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын

үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авна хэмээн тусгасан.

Манай хүн амын 83.4% нь хоногт дунджаар 5 нэгжээс бага жимс, ногоо хэрэглэдэг, 49.4% илүүдэл жинтэй, 18.5% таргалалттай байгаагаас харахад хүнсний ногоо, жимс жимсгэний хэрэглээг нэмэх, эрүүл зөв, аюулгүй хүнсээр хангах нь нэн чухал. Хүнсний хувьсгал амжилттай хэрэгжсэнээр хүнснээс шалтгаалсан өвчин эмгэг ч буурах ач холбогдолтой юм.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг хэрхэн хэрэгжүүлэх вэ?

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь эрүүл орчин – эрүүл хүнс – эрүүл хүн гэсэн харилцан уялдаатай байгаль экологийн загварт тулгуурласан хөтөлбөр юм. Энэ загвар нь эрүүл, аюулгүй байгаль орчныг бүтээж эрүүл, шимт хүнсний хэрэглээг дэмжин хүн-байгалийн шүтэлцээгээр хүний амьдарлын туршид дэмжих нийтийн эрүүл мэндийн арга хэмжээ юм.

Өнөөдрийн байдлаар Эрүүл мэндийн салбарт дарамт болж буй эрүүл мэндийн тэргүүлэх эрсдэлд зохисгүй хооллолт, архи тамхины хортой хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, түүнээс үүдсэн илүүдэл жин, таргалалт, артерийн даралт ихсэлт давамгайлж байна. Эдгээр шалтгааны улмаас үүссэн өвчнийг оношлох, эмчлэхэд эрүүл мэндийн салбарын санхүүжилтын дийлэнхи хувийг зарцуулж байна.

Судалгаанаас харахад хүн амын ердөө 3.9 орчим хувь нь л саяны дурьдсан эрсдэлгүй, эрүүл байна. Иймээс бид хүн амыг соён гэгээрүүлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл орчин, эрүүл хүнсээр хангах буюу өвчилсний дараа биш, харин түүнд хүргэдэг, нөлөөлдөг эрсдэлийг мэддэг, түүнээс сэргийлдэг, эрүүл ирээдүйг бий болгохын төлөө “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг эхлүүлсэн.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь Эрүүл зөв хооллолт, Эрүүл зан үйл, Эрүүл мэндийн боловсрол, Нийтийн биеийн тамир гэсэн үндсэн 4 бүрэлдэхүүнтэй. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхдээ судалгаанд тулгуурлан эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт, түүний суурь үзүүлэлтийг сум,сумаас аймаг, хороо, хорооноос дүүрэг, хот гэх мэт нэгжээс нь эхлэн өнөөгийн түвшинг тогтоон хэрэгжүүлнэ. Халдварт бус өвчний анхдагч эрсдэл болж буй архи, тамхины хэрэглээний түвшин,






жимс, хүнсний ногооны эрүүл зөв хэрэглээ, хөдөлгөөн, илүүдэл жин, таргалалт гэх мэт үзүүлэлтийг шалгуур үзүүлэлт болгон насны бүлэг, хүйс, оршин байгаа газраар нь гарган, хөтөлбөр хэрэгжихийн өмнөх үзүүлэлтэд тулгуурлан шинжлэх ухаанчаар төлөвлөн оновчтой үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлнэ. Иймээс “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь судалгаанд суурилсан Нийгмийн эрүүл мэндийн олон талт арга хэмжээ - интервенц юм.

Та судалгаанд суурилсан нийтийн эрүүл мэндийн арга хэмжээ гэж онцоллоо. Үүнийг тодруулж өгнө үү, тухайлбал ямар судалгаа хийгдсэн, яагаад судалгаа хийх нь чухал байна вэ?

Аливаа хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ одоогийн нөхцөл байдлыг тогтоох тухайлбал, хүн амын эрүүл мэнд хэр байна, ямар өвчин эмгэг давамгайлж, юу нөлөөлж байна, үүнийг яаж бууруулах гэсэн шийдлийг гаргахын тулд зайлшгүй тоо баримт, статистик мэдээлэл чухал. Өмнө хэлсэнчлэн хавдар, зүрх судасны эмгэг, чихрийн шижин, осол гэмтэл зэрэг монголчуудын өвчлөл, эндэгдлийн гол шалтгаан болоод байгаа халдварт бус өвчин нь (ХБӨ) сэргийлж болдог эмгэгүүд. Иймээс бид ХБӨ-ийн анхдагч эрсдэлийг хүн амын насны бүлэг, газар зүйн байршлаар харьцуулж үзэхэд хөтөлбөрийн шалгуур болох анхдагч эрсдэлийн мэдээлэл 2019 онд хийгдсэн СТЕП судалгаанаас харах боломжтой буюу 4 жилийн өмнөх үзүүлэлтийг одоогийн суурь түвшин болгон

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх таван шалтгаан, 2012-2021 он



авах боломжгүй хуучирсан тул бидэнд дахин судлах хэрэгцээ гарч байна. Иймээс Баянхонгор аймгийн хүн амын төлөөлөл 8900 орчим, Налайх дүүргийн хүн амын төлөөллийг хамруулан ХБӨ-ний анхдагч эрсдэлийг тогтоох судалгааг аймаг, дүүргийн удирдлага, эрүүл мэндийн төв, НЭМҮТ-тэй хамтран явууллаа. Энэ судалгаанд тулгуурлан Эрүүл сум, Эрүүл аймаг, Эрүүл дүүрэг хэмээх интервенцийн шалгуур, түүний суурь үзүүлэлт гарч улмаар 2022 - 2024, 2025 - 2027, 2027 - 2030 он гэсэн 3 шаттай хэрэгжих юм.

Бид 2021-2022 онуудад “Архи, согтууруулах ундаа, тамхи, чихэрлэг ундаанд ноогдуулах онцгой албан татварын тооцоолол, эрүүл мэнд, эдийн засгийн үр нөлөө”, “Тамхины хяналтын суурь конвенци ба түүний хэрэгжилт”, “Хүн амын согтууруулах ундаа, тамхины хэрэглээг эдийн засгийн бүлгээр тогтоох”, “Оюутан залуусын эрүүл мэндийн үнэлгээ” зэрэг хэд хэдэн томоохон судалгаа хийсэн, одоо ч зарим судалгаа үргэлжилж байна. Бид хийх ажлаа төлөвлөх, хэрэгжилтийн явцыг хянах, эргэн төлөвлөх, эрчимжүүлэх гэх мэт бүхий л шатанд бодит тоо баримт, шинжлэх ухааны нотолгоо зайлшгүй чухал тул энэ хөдөлгөөний салшгүй нэг хэсэг нь судалгаа юм.

Согтууруулах ундааны эрүүл мэнд, эдийн засгийн хор уршгийг бууруулахад Ерөнхийлөгч анхаарч, зарлиг ч гарлаа. Та энэ тал дээр тодруулж өгнө үү

Согтууруулах ундааны шалтгаант эмгэгийн тархалт, цаг бусын нас баралтаар манай улс дэлхийд тэргүүлж байна, насанд хүрсэн нэг хүнд ногдох хатуулаг өндөртэй архины хэмжээ тасралтгүй өссөөр байна. Зөвхөн архи, тамхины шууд ба шууд бус нөлөөний улмаас жилд 9000-10 000 орчим иргэн амь насаа алдаж байгаа нь нийт нас баралтын 60 орчим хувийг эзэлж байна. Эндээс харахад өвчин хийсэж биш хэлж ирдэг, та бидний зуршил, зан үйл, дадлаас хамаарч байна. Олон сайхан залуус архины зохисгүй хэрэглээнээс үүдэн амь насаа алдаж, эрх чөлөөгөө хязгаарлуулж, гэр бүл салж, хүүхэд эрсдэж, гэмт хэрэг зөрчлийн дийлэнх нь согтууруулах ундаанаас хамаарч байна.

Дэлхийн улс орны сайн туршлагаас харахад согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлахад

татварын зөв бодлого, үнийн өөрчлөлт, тодорхой сегментэд чиглэсэн интервенц үр дүнгээ өгдөг. Иймд бид архинд ногдуулах Онцгой албан татварын тооцоолол, түүний эрүүл мэнд, эдийн засгийн үр нөлөөг олон хувилбараар тооцож, түүнд тулгуурлан 2022 оны 4 сарын 5- ны өдөр Ерөнхийлөгчийн 43 тоот зарлиг гарсан. Уг зарлигийн хэрэгжилтийн хүрээнд 2022 оны 7 сард “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай” хууль шинэчлэгдлээ. Үүнтэй уялдан дагалдах хуулиудад томоохон өөрчлөлт хийгдэн 2023 оноос согтууруулах ундааны хатуулагаас хамааран Онцгой албан татварыг дунджаар 2 дахин нэмж, литр тутмын борлуулалтаас 300 төгрөгийг Эрүүл мэндийн боловсрол олгох, Нийгмийн эрүүл мэндийн тусламжид зарцуулах бие даасан сан байгуулахаар дагалдах хуулиудад өөрчлөлт орлоо. Мөн архи, согтууруулах ундааны эрүүл зөв хэрэглээг төлөвшүүлэх, өндөр хатуулагтай архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах чиглэлд бодлогын болон эрх зүйн өөрчлөлт хийх; Онцгой албан татварын ангилал, шатлалд өөрчлөлт оруулах замаар 38 хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааны хатуулгийг 10 жилийн хугацаанд жил бүр 2 хувиар бууруулах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх өөрчлөлт хийгдлээ.

Бид согтууруулах ундааны эрүүл мэнд, эдийн засгийн хор хөнөөлийг нийгэм, ард иргэдэд таниулах, нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттай явуулж байна. Өнгөрсөн 11-12 сард залуусд чиглэсэн “Намайг алгас” аяныг ЦЕГ-тай хамтран амжилттай хэрэгжүүлснээр залуусд соёлтой хэрэглээг төлөвшүүлэх, согтууруулах ундаанаас татгалзах олон талт нөлөөллийн үйл ажиллагаа явуулсан. Ингэснээр өдөрт бүртгэгдэх архины шалтгаант хэрэг зөрчил, гэмт хэрэг, хүчирхийлэл эрс буурсан.

Эндээс харахад иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг тогтмол, оновчтой арга замаар хүргэх нь нэн чухал байна. Мөн эрүүл зан үйл, ялангуяа согтууруулах ундаа, тамхины хэрэглээг бууруулах, зөв дадал, зуршилтай иргэнийг бид цэцэрлэг, сургуулиас нь төлөвшүүлэх нь шаардлагатай юм.





ХҮМҮҮНЛЭГ, ЭРҮҮЛ ЧИЙРЭГ, ИДЭВХТЭЙ, БҮТЭЭЛЧ ИРГЭН, ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА ХИЧЭЭЕ

*Б.Бат-Эрдэнэ,
Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн
газрын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн
биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга*



Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг баталсан бөгөөд энэхүү бодлогын баримт бичгийн гуравдугаар бүлэг “Амьдралын чанар ба дундаж давхарга”, “Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг” хэсэгт биеийн тамир, спортын салбарын урт хугацааны зорилтыг тодорхойлсон.

Биеийн тамир, спортын салбарын урт хугацааны зорилтыг “Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ” гэж заажээ.

Аливаа улс орны хөгжлийн тулгуур нь хүн хэмээн тунхаглан хүний хөгжлийн асуудлыг дэлхий нийт даяар ярьж байна. Үүний нэгэн адил Монгол Улс хүнээ хөгжүүлэх, түүний дотор биеийн тамир, спортоор дамжуулан идэвхтэй амьдралын хэв маягтай, хүмүүнлэг, эрүүл чийрэг, бүтээлч иргэн, гэр бүлийг бий болгож дэмжих асуудлыг урт хугацааны хөгжлийн бодлогодоо тусган хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газар болон төрийн бүх шатны байгууллагууд зүтгэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс улс, үндэстний оршин тогтнох болон хөгжлийн асуудалд анхаарал тавьж “Тэрбум мод”, “Хүнсний хувьсгал”, “Эрүүл Монгол хүн” санаачилга эхлүүлж, амжилттай хэрэгжүүлж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн энэ удаагийн санаачилга нь “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд идэвхтэй дасгалын чиглэлийг тусган хэрэгжүүлж байгаад биеийн тамир, спортын салбарынхан тааламжтай хандаж байна.

Монгол Улсын төр засаг, ард иргэд хамтран спортын амжилтаа олимпын тавцанд гаргаж чадсантай адилаар иргэн бүр өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэндэд анхаарлаа хандуулан хичээж, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэхдээ цаг гаргаж, нийгэмдээ зөв, эерэг хандлага бүрдүүлж эрүүл, идэвхтэй иргэн, гэр бүл бий болгоцгооё.



ЭРҮҮЛ МОНГОЛ ИРГЭН, ЭРҮҮЛ ГЭР БҮЛ, ЭРҮҮЛ ХАМТ ОЛНЫГ ОЛНООР БИЙ БОЛГОХЫН ТӨЛӨӨ БИД ХАМТРАН АЖИЛЛАНА

*С.Чинзориг,
Улсын Их Хурлын гишүүн,
Монгол Улсын Засгийн газрын гишүүн,
Эрүүл мэндийн сайд*



Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болохоор алсын харааг тодорхойлж, монгол хүний эрүүл, урт удаан амьдралын нөхцөлийг хангаж, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн дундаж наслалтыг 2030 онд 78, 2050 онд 82-т хүргэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Монгол Улсын хүн амын дунд урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж эмчлэх боломжтой халдварт болон халдварт бус өвчний шалтгаант өвчлөл, нас баралт жилээс жилд нэмэгдэж байгаа нь эрчимтэй хотжилт, шилжилт хөдөлгөөн, орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт, хувь хүний амьдралын хэв маяг, зан үйл, нийгмийн хүчин зүйлсээс хамаарч байна. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлж, тархалтыг бууруулснаар өвчлөл, нас баралт, хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдлыг 50 хүртэлх хувиар бууруулах боломжтой бөгөөд хүнсний бүтээгдэхүүнийг зөв сонгон хэрэглэж, архины хэрэглээг багасган, тамхинаас татгалзан биеийн жингээ хэвийн хэмжээнд барьж, дасгал хөдөлгөөнийг эрхэмлэж чадвал зүрх судасны өвчин, тархины харвалт, хоёр дугаар хэлбэрийн чихрийн шижинг 80%, хорт хавдрыг 40%-иар бууруулж болно. Монгол Улсын халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын IV судалгаагаар 15-69 насны нийт хүн амын 4 хүн тутмын нэг нь халдварт бус өвчний 3 ба түүнээс дээш эрсдэлт хүчин зүйл илэрч байгаа бөгөөд аль нэг эрсдэлт хүчин зүйлийн нөлөөнд автаагүй хүн амын эзлэх хувь дөнгөж 3.9% байгаа нь хүн амын дунд эрүүл амьдралын хэв маяг, дадал зуршил хэвшээгүй, эрүүл сонголт хийх боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Эрүүл мэндийн талаар дэлхий нийтэд баримталж буй бодлого, чиглэл, үйл ажиллагаа нь дан ганц өвчнийг эмчлэхэд бус хүн амд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл идэвхтэй амьдрах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, ажиллаж, амьдарч, сурч байгаа орчиндоо эрүүл мэндэд таатай нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлэхэд нь хувь хүн, олон нийт, байгууллага, хамт олонд туслах, олон салбарын хамтын үйл ажиллагааг чиглүүлэх замаар хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулахад чиглэгдэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар хэрэгжүүлж буй архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, эрүүл хоол хүнсний хэрэглээг бий болгоход салбар хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлэх “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөн нь цаг үеэ олсон, нэн чухал арга хэмжээ болж байна.

Эрүүл Монгол иргэн, эрүүл амьдралын дадал, зан үйлийг төлөвшүүлсэн эрүүл гэр бүл, хамт олныг олноор бий болгохын төлөө бид хамтдаа хичээн ажиллах болно.

Та бүхэнд эрүүл, идэвхтэй амьдралыг хүсэн ерөөе.





ЭРҮҮЛ БИЕД, САРУУЛ УХААН ОРШИНО

*А.Энх-Амгалан
Улсын Их Хурлын гишүүн,
Монгол Улсын Засгийн газрын гишүүн,
Боловсрол Шинжлэх Ухааны Сайд*



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар хэрэгжиж буй үндэсний хөдөлгөөний нэг нь “Эрүүл Монгол хүн” бөгөөд энэ нь Монгол хүний эрүүл мэндийг хамгаалах, эрүүл залуу үеийг дэмжих цаг үеэ олсон, хамгийн чухал санаачлага юм. Ялангуяа хүн амын архи, согтууруулах ундааны хортой хэрэглээ, түүнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор 2022 оны 4 сарын 5-ны өдрийн 43 дугаар зарлиг гарган холбогдох хуулиудад томоохон өөрчлөлт орон, хэрэгжиж эхлээд байгааг дурьдахад таатай байна.

Монгол хүний эрүүл мэндийн нөхцөл байдалд онцгой анхаарал хандуулж, тусгайлсан бодлого, арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь өдөр тутам тодорхой харагдаж байна. Олон улсын эрүүл мэндийн байгууллагын хийсэн судалгаагаар “Эрүүл мэндийн өвчлөл, эрсдэлийг бага наснаас илрүүлж, зохих арга хэмжээ авч чадвал насанд хүрэгчдийн дундах өвчлөл буурдаг” гэсэн дүгнэлт байдаг. Энэ нь хүүхэд, залуучуудын эрүүл мэндэд боловсролын салбар чухал хувь нэмэр оруулж чадна гэсэн үг юм.

Боловсролын эрх зүйн шинэчлэлээр хүүхэд, залуучуудад эрүүл амьдралын хэв маяг, ур чадвар, хандлагыг төлөвшүүлэх агуулгыг боловсролын бүх түвшний сургалтад заавал тусгах зохицуулалтыг тусгаад байна. Энэхүү агуулгыг эрүүл мэнд, биеийн тамирын хичээлийн хөтөлбөрөөр олгохоос гадна дугуйлан, клуб болон нийгэм, сэтгэл хөдлөлийн ур чадвар, эрүүл амьдралын дадлыг сургалтаас гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан хөгжүүлэхтэй холбоотой заалтыг мөн тусгаад байна. Суралцагчдыг 6, 9, 12, 15 насанд нь эрүүл мэндийн илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах замаар хүүхдийн эрүүл мэндийг бага наснаас нь хамгаалах, шаардлагатай үед нь эрүүл мэндийн байгууллага, сургууль хамтран арга хэмжээ авах, суралцагчдын эрүүл мэндийн хяналт, тандалтыг тогтолцоо бүрдүүлэх, зохицуулалт хийх боломжийг ажлын хэсэгтэй хэлэлцэж байна.



Сургалтын орчин хүүхэд, залуучуудын эрүүл мэндийн салшгүй хэсэг байдаг. Үүнтэй холбогдуулан эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан орчныг бүрдүүлэх асуудлыг хуулийн шинэчлэлд тусган ажиллаж байна. Материаллаг орчноос гадна сэтгэл зүйн орчны асуудал хүүхэд, залуучууд архи, тамхи гэх мэт хот зуршлаас ангид байх, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулахад хамгийн чухал асуудал байдаг учраас сургууль бүр сэтгэл зүйчтэй байх зохицуулалтыг мөн хуулийн шинэчилсэн найруулгад орууллаа.

Хуулийн шинэчлэлээс гадна өнөөг хүртэл эрүүл Монгол хүүхдийг төлөвшүүлэх чиглэлээр нэлээдгүй ажлыг амжилттай эхлүүлээд байна. Юуны өмнө “хүртээмжээс-чанарт” уриатай гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд хувьсах зардлын бүрэлдэхүүнд эрүүл мэндийн яамнаас зохион байгуулж буй эрт илрүүлгийн шинжилгээний багцад ороогүй, багшийн ажлын онцлогоос хамаарсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээний зардлыг баталж, хэрэгжүүлснээр өнөөдрийн байдлаар 40,000 орчим багш үзлэг, шинжилгээнд хамрагдаад байна. Мөн сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд “Эрүүл сургууль” индексийн шалгуурыг оруулж байна. Эрүүл мэндийн яамтай хамтран ажиллаж байна. 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн 5-6 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээнд эрүүл мэндийн тандалт, илрүүлгийг хийхээр бэлтгэж байна.

“Эрүүл Монгол хүн” санаачлага хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн нийгмийн үйлчилгээнд чухал шинэчлэл болно гэж үзэж байна. Энэ чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны яамны манлайлал, санаачилгаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар дундын тогтолцооны зураглалыг шинэчлэх ажлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран эхлүүлээд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх салбар дундын тогтолцоог шинэчлэхдээ байгууллагад бус тухайн иргэнд шаардлагатай үйлчилгээнд суурилсан тогтолцоог бий болгоход голлон анхаарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд боловсрол эзэмших зардлыг үйлчилгээний бодит өртөгт суурилан тооцоолж, хэрэгжүүлэхэд бэлэн болголоо. Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрт илрүүлэгт хамрагддаг байх, ингэхдээ зөвхөн эрүүл мэнд талаасаа бус танин мэдэхүйн бэрхшээлтэй холбоотой эрт илрүүлэгт хамрагдаж, бага наснаас нь эрт оролцооны хөтөлбөрт хамруулах, хөгжлийг дэмжих чиглэлээр дэмжих үйлчилгээг туршилт байдлаар цэцэрлэг, сургууль дээр хэрэгжүүлж байна.

Монгол улсын хувьд шүд цоорох өвчний тархалт буурахгүй, жилээс жилд улам бүр нэмэгдэж байна. Боловсрол, шинжлэх ухааны яам сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын насны хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах чиглэлээр “Шүд” төслийг Эрүүл мэндийн яамтай хамтран хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд шүдний үзлэгт 0-17 насны хүүхдүүд хамрагдсан ба тэдгээрийн 238,184 шүдний ямар нэг өвчтэй болон өвлөх эрсдэлтэй гэж бүртгэгдсэн. Эдгээр хүүхдүүдийг шүдний эмчилгээнд үе шаттай хамруулж байна.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд боловсролын салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн нэг нь суралцагчийн Үдийн хоол хөтөлбөр юм. Одоогоор бага ангийн сурагчдад үдийн хоол өгч байгаа ба цаашид дунд болон ахлах ангийн суралцагчдад үдийн хоолоор үйлчилнэ. 2023 онд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрын хүүхдийн хоолны зардлын нормативыг 1300 төгрөгөөр нэмэгдүүлэн 4300 төгрөг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын ахлах ангийн хүүхдийн хоолны зардлын нормативыг 825 төгрөгөөр нэмэгдүүлэн 4300 төгрөг, дунд болон бага ангийн хүүхдийн хоолны зардлын нормативыг 525 төгрөгөөр нэмэгдүүлэн 4000 төгрөг болгон нэмэгдүүлээд байна.

Эрт үеэс Монголчууд “Эрүүл биед саруул ухаан оршино” гэдэг билээ. Уламжилж ирсэн энэ дадлыг баримтлан эрүүл байж, эрдэм боловсролтой болохыг хамтаараа эрмэлзье.

Та бүхэнд эрүүл, энхийг хүсье.





“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН: МОНГОЛЧУУДЫН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ, ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ

Др. Сокорро Эскаланте
ДЭМБ-ын Монгол Улс дахь Суурин төлөөлөгч

“Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөнийг санаачлан хэрэгжүүлж буй Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх танд бид чин сэтгэлийн баяр хүргэе. Өмнөх уулзалтын үеэр ерөнхийлөгчийн Нэг тэрбум мод санаачилга Монгол хүн бүрийн зүрх сэтгэлд хүрснийг мэдэрч биширсэн. Бид “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөнийг үүний нэг адилаар чухалчлан хүлээж авч байна.

Сүүлийн арван жилүүдэд Монгол хүний эрүүл мэнд эрс сайжирч, дундаж наслалт нь 1965 онд 66.5 байсан бол өдгөө 70.7 болжээ. Үүний сацуу эх, нярайн нас баралт тасралтгүй буурч, халдварт өвчин багасаж, улмаар нийтийн эрүүл мэндэд чухлаар нөлөөлсөн байна. Дээрх амжилтууд нь маш сайн бүтэц, зохион байгуулалт бүхий анхан шатны тусламж үйлчилгээ, өрх бүр, малчин бүрт хүрч чадсан эрүүл мэндийн салбар, хүчирхэг нийгмийн эрүүл мэндийн тогтолцоонд суурилжээ. Энэхүү цогц системээр дамжуулан Монгол Улс нь КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг маш үр дүнтэй авсан улс орнуудын нэг болсон. Улс орон хурдан хөгжихийн хэрээр шинэ саад бэрхшээл бий болж байна. Үүнд тухайлбал, хүн амын амьдралын хэв маяг өөрчлөгдөж халдварт бус өвчний эрсдэл ихсэх, хотжилт, цаг уурын өөрчлөлт, байгаль орчны асуудал нь хүний эрүүл мэнд, сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлж байна.


Нэн тэргүүнд, энэхүү хөдөлгөөн хөтөлбөр нь бидний анхаарлыг хувь хүн, нийт хүн амын эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих, хадгалахад чиглүүлж байгаа ба ингэснээр хүн бүр эрүүл мэндийн хамгийн боломжит өндөр түвшинд амьдрах эрхээ арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, улс төрийн итгэл үнэмшил, нийгэм эдийн засгийн байдлаас үл хамааран харгалзан эдлэх ёстой гэсэн зарчмыг удирдлага болгож байна. Үүний тулд орчин нөхцөлийг бий болгох, хүн бүрт хөгжих боломжийг тэгш олгох бодлого, хууль эрх зүйн орчин, хөтөлбөрүүд хэрэгтэй.

Хоёрдугаарт, энэ нь эрүүл мэндийг хөгжлийн бодлогын тухайлбал 2050 алсын харааны төвд тавьж, ирээдүй үеийнхний эрүүл мэндэд улс орны хөгжлийн үр шим хамгийн ихээр нөлөөлөх боломжийг бий болгож байна. Гуравдугаарт, анхан шатын болон эмнэлэг, эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхийн сацуу бусад салбарыг оролцуулах нөхцөлийг бий болгож байгаа нь хүн амын эрүүл мэндэд гарах үр дүнг сайжруулж байна. Тухайлбал, дэд бүтэц, цахилгаан, ариун цэврийн байгууламж, ногоон эрчим хүч, сайжруулсан орон байрны хүртээмжийг нэмэгдүүлэх нь урт хугацааны хөрөнгө оруулалт бөгөөд өргөн утгаараа хүн амын эрүүл мэндийг улам сайжруулахад нөлөөлдөг. Үүнээс гадна Эрүүл Монгол Хүн үндэсний хөдөлгөөн нь эрүүл мэндийг нийгмийн үнэт зүйл болгон эрхэмлэн дээдэлж, архи, тамхины хэрэглээг бууруулах, эрүүл хооллолт, эрүүл мэндийн боловсрол, бүх нийтийн спорт, эрүүл орчныг дэмжиж байгаа нь чухал юм.

Эцэст нь ДЭМБ-ын хамт олны өмнөөс Монгол хүний эрүүл мэндийн төлөө хичээнгүйлэн зүтгэж буй Ерөнхийлөгчийн Тамгын газар, хамт олонд дахин баяр хүргэе. Монгол хүн бүрийн эрүүл мэндийг хамгаалах энэхүү чухал ажилд ДЭМБ гар бие оролцож байгаа нь бидний хувьд нэр төрийн хэрэг билээ.

■ ХОЁР

“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН





ЗОРИЛГО:

Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгон зан үйлийг өөрчлөх замаар бие бялдар, сэтгэц, танин мэдэхүйн хувьд эрүүл, өв тэгш Эрүүл Монгол хүнийг төлөвшүүлэх



**ЭРҮҮЛ МОНГОЛ
ХҮН ГЭДЭГ НЬ:**

- Эрүүл бие бялдартай
- Эрүүл саруул оюун ухаантай
- Эрүүл зан үйл, амьдралын хэвшилтэй
- Эрүүл орчинг бүтээгч



**ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ҮНДЭСНИЙ
ХӨДӨЛГӨӨН ХЭСЭГ:**



ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ:

- Судалгаанд суурилсан
- Олон хувилбарт
- Салбаруудын уялдааг хангасан
- Иргэдийн оролцоонд тулгуурласан
- Инноваци, технологийн шинэ шийдлийг ашигласан
- Хариуцлага, ёс зүйг эрхэмлэсэн
- Гүйцэтгэл, үр дүнг тооцсон зарчмаар хэрэгжүүлнэ



“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР



Эрчүүд – 1.65 сая


0-19 насны хүүхэд, залуус-1.2 сая
Оюутан - 145 мянга

Өндөр настан 232 мянга
Нялхас -70 мянга
Эхчүүд – 660 мянга
Нийт эмэгтэй-1.7 сая

Чиглэл:

- Эрүүл зан үйл – архи, тамхины хэрэглээг бууруулах
- Идэвхтэй хөдөлгөөн
- Зөв хооллолт
- Эрүүл мэндийн боловсрол

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭКОЛОГИЙН МОДЕЛ





ЭРҮҮЛ МЭНД ТАНЫ ЭРХЭМ БАЯЛАГ, ҮНЭТ ЗҮЙЛ

*Очирын Чимэдсүрэн
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын
“Эрүүл Монгол хүн” төсөл, хөтөлбөр хариуцсан
албаны дарга, АУ-ны доктор, Профессор*

Нийтийн эрүүл мэндийн тусламж нь төр, хувийн хэвшил, хамт олон, хувь хүмүүсийн оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурласан эмгэгээс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, хамгаалахад чиглэсэн олон талт үйл ажиллагаа юм. Тиймээс нийтийн эрүүл мэндийг хүний сайн сайхны төлөөх шинжлэх ухаан, урлаг гэж зарим эрдэмтэд томъёолсон байдаг. Эмнэлзүйн анагаах ухаан нь хувь хүний түвшинд өвчнийг илрүүлэх, оношлох, эмчлэх, сэргээн засахад чиглэдэг бол Нийтийн эрүүл мэнд нь хүн ам, тодорхой бүлэг, хамт олны эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйл, эрсдэлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг олон талт үйл ажиллагаанаас бүрддэг. Монголчуудын өвчлөл, эндэгдлийн дийлэнх хувийг сэргийлж болох өвчлөл буюу зүрх судас, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг, хавдар, осол гэмтэл эзэлж байна. Эдгээр өвчний эрсдэл, гол шалтгаан нь тухайн хүний архи, тамхины хэрэглээ, хооллолт, хөдөлгөөний идэвх зэргээс шалтгаалдаг болохыг шинжлэх ухаан нотолж, түүнээс сэргийлэхийн тулд нийтийн эрүүл мэндийн цогц интервенц чухал болохыг олон орны туршлага харуулж байна.

Нийтийн эрүүл мэндийн тусламж бол нэг удаагийн аян, арга хэмжээ, тэмдэглэлт өдөр, өдөрлөг биш. Харин тухайн хүн ам, хамт олны эрүүл мэндийг хянах, өвчлөлд хүргэж буй эрсдэлийг тогтоох, түүнд тулгуурлан хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, нөөцийг бүрдүүлэхэд чиглэсэн шат дараатай, зохион байгуулалтай, тасралтгүй урт хугацааны үйл явц юм. Хэдийгээр эрүүл мэндийн тухай хуульд Нийтийн эрүүл мэндийн тусламжийг эрүүл мэндийн тусламжийн тэргүүлэх чиглэл хэмээн заасан хэдий ч түүнийг хэрэгжүүлэх бодлого, хүний нөөц, зохион байгуулалт, оновчтой менежмент, санхүүгийн шийдэл хүлээгдсэн хэвээр байна. Бодлого боловсруулах түвшинд гаргаж буй аливаа шийдвэр нь шинжлэх ухааны нотолгоонд тулгуурлах өөрөөр хэлбэл хэрэгжүүлэхийн өмнө хэрэгцээг тогтоох, үр дүн өгөхүйц арга, хэлбэрийг сонгох, явцыг үнэлэх нь оновчгүй олон хөтөлбөр хэрэгжих, үргүй зардал гарахаас сэргийлэх ач холбогдолтой юм. Нийтийн эрүүл мэндийн тусламж хэрэгжүүлэхгүйгээр өвчлөлийг бууруулах боломжгүй бөгөөд салбарын зардлын дийлэнх нь өвчилсөний дараах эмчилгээнд зарцуулсаар байх болно. Иймд Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөний хүрээнд Нийтийн эрүүл мэндийн цогц, шинэлэг, нотолгоонд тулгуурласан үйл ажиллагааг салбаруудын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэхээр зорьж байна.

Та бүхнийг Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөнд түүчээлэн оролцож, олон жил эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудал болон үргэлжилж буй халдварт бус өвчний тархалтыг хязгаарлах, Монгол хүний эрүүл мэндийг дэмжин, хамгаалах их үйлсэд нэгдэхийг уриалж байна.



ЭРХЭМ ЗОРИЛГО:

Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгон зан үйлийг өөрчлөх замаар бие бялдар, сэтгэц, танин мэдэхүйн хувьд эрүүл, өв тэгш Эрүүл Монгол хүнийг төлөвшүүлэх

Зорилт 1: Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөнийг судалгаанд суурилан, салбаруудын уялдаа болон иргэд олон нийтийн оролцоог ханган нийтийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох, соён гэгээрүүлэхэд чиглүүлэн хэрэгжүүлэх

Зорилт 2: Эрүүл ирээдүйг бий болгохын тулд бүх шатны боловсролын хөтөлбөр дэх эрүүл мэнд, бие бялдын хөгжил, зөв хооллолт, эрүүл зан үйлийн сургалтын агуулга, арга зүйн цогц өөрчлөлтийг хийхэд холбогдох талуудтай хамтран ажиллах

Зорилт 3: Сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалт, бүртгэл мэдээллийн тогтолцоог бүрдүүлж суралцагчдын эрүүл мэндийн цахим мэдээний сан үүсгэн, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих

Зорилт 4: Хүн амын дундах архи согтууруулах ундаа, тамхины хэрэглээг бууруулах, эрх зүйн орчныг сайжруулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, цогц нөлөөллийн ажлыг явуулах

Зорилт 5: Эрүүл аюулгүй, чанартай, шимт хүнс ялангуяа хүнсний ногоо, жимс жимсгэний хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх, үдийн хоол, үдийн цай хөтөлбөрийг оновчтой хэрэгжүүлж хоол хүнсний зохистой хэрэглээг нэмэгдүүлж, шим тэжээлийн дутагдлыг багасгахад холбогдох талуудтай хамтран, хэрэгжилтийг эрчимжүүлэх

Зорилт 6: Хөдөлгөөний хомсдолоос шалтгаалан иргэдийн насжилтад сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг багасгаж, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих ээлтэй орчныг бүрдүүлэн амьдралын чанарыг сайжруулах

Зорилт 7: Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй эрх зүйн баримт, нөлөөллийн арга хэмжээний төлөвлөлт, зохион байгуулалт, санхүүжилт, үр нөлөөний талаар бодлогын судалгаа хийж, эрүүл мэндийн тусламжийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Зорилт 8: Нийтийн эрүүл мэнд, соён гэгээрүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих, суурь ба анхдагч сэргийлэлтэд чиглэсэн нийтийн эрүүл мэндийн тусламжийг өргөжүүлэх чиглэлд холбогдох талуудтай хамтран ажиллах

Зорилт 9: Инноваци, дижитал технологийн дэвшилд тулгуурлан эрүүл мэндийн боловсрол олгох, эрсдэлийг илрүүлэх, сэргийлэх, хянах, зөвлөн туслах цахим мэдлэгийн сан, цахим үйлчилгээг нэвтрүүлэх



Эрүүл Монгол хүн - Насан туршийн эрүүл мэнд

- Эрсдэл, шалтгааныг тогтоох
- Эрт илрүүлэг
- Сэргийлэлт
- Хяналт
- НЭМ тусламж

- Одоогийн менежмент
- Өвчин хайх илрүүлэг
- Хожуу оношилгоо
- Эмчилгээ

- Өвчилсөн хүн амд чиглэсэн
- Эрсдэлт шалтгааны улмаас эмгэг үүссэн





ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮНИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАЙЛШГҮЙ ШААРДАГАТАЙ БАЙНА

*С.Өнөрсайхан,
НЭМҮТ-ийн захирал, ШУ-ны доктор,
дэд профессор*

Дэлхийн хэмжээнд хүн амын өвчлөл, нас баралтад нөлөөлж байгаа зонхилох 10 эрсдэлт хүчин зүйлээс хамгийн түгээмэл, анхдагч эрсдэлт хүчин зүйлс нь зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхины хэрэглээ бөгөөд эдгээр нь илүүдэл жин, цусны даралт ихсэлт, цусны өөх тос, саахар(глюкоз)-ын хэмжээ нэмэгдэх зэрэг завсрын хүчин зүйл байдлаар илэрч, улмаар өвчлөл, нас баралтад хүргэж байгааг ДЭМБ тогтоогоод байна.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын нийгэм, эдийн засагт хийсэн шинэчлэлийн нөлөөгөөр хүн амын өвчлөл, нас баралтын бүтцэд өөрчлөлт гарч, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээ өсөн нэмэгдэж байна. Хүн амын нас баралтын шалтгааны дотор, урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж эмчлэх боломжтой халдварт бус өвчин (ХБӨ) давамгайлж, монгол хүний дундаж наслалтад ч нөлөөлж байна.

ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлсийг танин мэдэж, улмаар түүнээс сэргийлж чадвал зүрх судасны өвчин, тархины харвалтыг 80%-иар, хавдрыг 40%-иар, чихрийн шижин хэв шинж 2-оос бүрэн сэргийлэх боломжтойг эрдэмтэд судлан тогтоосон байдаг. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтод “Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх замаар цаг бусаар нас барах явдлыг 2025 он гэхэд 25%, архины хортой хэрэглээ, хөдөлгөөний хомсдлыг 10%, давс, тамхины хэрэглээг 30%, цусны даралт ихсэлтийг 25%, таргалалт, чихрийн шижингийн өсөлтийг тогтоон барихаар, Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.2.2-ын 3 дахь зорилтод “2021-2025 онд хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнд чанар, стандартыг чанд мөрдүүлэх, 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 16.0, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 9 хүртэл бууруулахаар заасан.

2019 онд “ХБӨ, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа”-г Монгол улсын үндэсний хэмжээнд 4 дэх удаагаа гүйцэтгэж, үнэлгээг өгөхөд ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн ам дөнгөж 3.9% байх бөгөөд манай улсын 45-69 насны хүн амын талаас илүү буюу 51.2% нь ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй байгаа нь анхаарал татаж байна.

Хүн амын дунд зонхилон тохиолдох ХБӨ-ий тархалтыг бууруулах чиглэлээр байгууллага, хамт олон, нийгмийн салбар, олон улсын байгууллагын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах, хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн тогтолцоог бэхжүүлэх, олон талт байгууллагуудын оролцоонд тулгуурлан ХБӨ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүс нутгийн ялгаатайгаар хэрэгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлтэй нотолгоог бий болгож, Эрүүл Монгол хүнийг хөгжүүлэх зайлшгүй шаардлага бидний өмнө тулгараад байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газраас хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний үзэл баримтлал, хэрэгжүүлэх арга зам, мөн архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулахад салбаруудын оролцоог эрчимжүүлэх ажлууд нь цаг үеэ олсон маш чухал бөгөөд эрүүл мэндийн ажилтан бүрийн оролцоотойгоор амжилттай хэрэгжинэ гэдэгт итгэлтэй байна.



2.1 “ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН”

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний бүрэлдэхүүний нэг нь нийтийн биеийн тамир, идэвхтэй дасгал хөдөлгөөн бөгөөд өрсөлдөх чадвартай, эрүүл амьдралын дадалтай, сэтгэлийн хатуужилтай шинэ үеийг бий болгоход идэвхтэй дасгал хөдөлгөөн чухал үүрэгтэй. Хүүхэд, залуучуудыг нийтийн биеийн тамираар хичээллүүлэх нь эрүүл чийрэг бие бялдар, өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх ач холбогдолтой бол идэр, хижээл настнуудад эрт хөгшрөлтөөс урьдчилан сэргийлэх зөв дадал болно.

Иймд бид иргэдэд бие бялдрын боловсрол олгох, тогтмол идэвхтэй хөдөлгөөн хийх мэдлэг, дадал эзэмшүүлэх, мөн иргэдийн эрүүл мэндэд хөдөлгөөний хомсдолоос шалтгаалсан сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв тодорхойлох дэд тогтолцоог бүрдүүлж эрүүл, идэвхтэй амьдралын хэвшилтэй Монгол хүнийг төлөвшүүлэхэд хувь хүн, гэр бүл, хамт олны оролцоонд тулгуурлан олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Хөдөлгөөний хомсдолоос шалтгаалан иргэдийн насжилтад сөрөг нөлөөлөл үзүүлж буй хүчин зүйлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, цахим технологид суурилан зөв тодорхойлох, тогтмол идэвхтэй хөдөлгөөн хийх мэдлэг, дадал эзэмшүүлэх, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлэх.



ЗОРИЛТУУД:

1. Хөдөлгөөний хомсдолоос шалтгаалан иргэдийн насжилтад сөрөг нөлөөлөл үзүүлж буй хүчин зүйлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, цахим технологид суурилан зөв тодорхойлодог болох;
2. Биеийн онцлог, сонирхолд нийцсэн спорт, идэвхтэй хөдөлгөөний талаарх мэдлэг, хандлага, дадлыг эзэмшсэн идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэдийн тоо нэмэгдүүлэх;
3. Спорт, идэвхтэй хөдөлгөөний үйлчилгээг хувийн хэвшил, спортын холбоо, спортын клубийн оролцоонд тулгуурлан хөгжүүлэх, эрчимжүүлэх;





МОНГОЛ ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД БОЛ ТӨРИЙН БОДЛОГООС АНГИД БАЙХ ЁСГҮЙ, ТӨР БОЛОН ИРГЭН БҮРИЙН ХАМТЫН ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ

*М.Болд,
Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх*



Өнөө үед халдварт бус өвчлөлийн тархалт хурдацтай нэмэгдэж, хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааныг тэргүүлж, дэлхий дахины тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. Ялангуяа сүүлийн хориод жилд дэлхийн хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааны бүтцэд өөрчлөлт орж, хүн амын зан үйл, дадал хэвшилтэй илүү хамааралтай болоод байна. Монголчууд бид жилийн дөрвөн улиралд буурь сэлгэн нүүдэллэдэг нүүдэлчин соёл иргэншилтэй, мал аж ахуй эрхэлж байсан уламжлалтай, түүндээ тохирсон байнгын хөдөлгөөнтэй амьдралын хэв маягтай байсан. Нийгмийн хөгжлийн явцад манай орон нүүдлийн болон суурин соёл иргэншил хосолсон өвөрмөц орон болж, хүн амын талаас илүү хувь нь суурин амьдралд шилжиж, хотжилт эрчимтэй явагдаж байна. Үүнийгээ дагаад хүн амын дунд хөдөлгөөний хомсдол ихсэж, илүүдэл жин, таргалалт, зүрх судасны өвчин, артерийн даралт ихсэлт гэх зэрэг өвчний эрсдэл нэмэгдэж, зарим өвчний үзүүлэлтээр дэлхийд нэгдүгээрт бичигдэх боллоо. Монголчууд бүх нийтээрээ эрүүл мэнддээ анхаарч, эрүүл амьдралын хэвшлийг эрхэмлэх нь өнөөдөр нэн тэргүүний асуудал болоод байна. Энэхүү нөхцөл байдлыг Монгол Улсын Ерөнхийлөгч анхааралдаа авч “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Идэвхтэй хөдөлгөөн” хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөн амжилттай эхлүүлснийг иргэд, спортын байгууллага, холбоод нэн талархалтайгаар хүлээн авч хамтран ажиллаж байгаад гүнээ талархаж байна. Монгол хүний идэвхтэй хөдөлгөөн, спортоор тогтмол хичээллэгчдийн тоог Азийн улс орнуудаар харьцуулахад Ази тивийн дундаж 60 хувь байхад бид дөнгөж 17 хувьтай байгаа нь идэвхтэй дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийн боловсролдоо анхаарах цаг болсныг илтгэж байна.

Бид “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэдэд бие бялдрын боловсрол олгох, өөрийн нас бие, эрүүл мэндэд тохирсон идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх дадлыг эзэмшүүлж, амьдралын хэвшил болгох тодорхой зорилт тавьж байна. Мөн хүүхэд өсвөр үед бие бялдрын боловсролыг олгож өөрийн биеийн онцлог, сонирхолд нийцсэн спортын төрлөөр зөв хичээллэж хөдөлгөөний хомсдолд орохгүй илүүдэл жин ба таргалалтгүй байх мэдлэг, дадал эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийг сайжруулан, сонгон суралцаж хичээллэх дугуйлангын хөтөлбөрүүдийг хөгжүүлэн эрүүл мэндийн боловсролтой эрүүл чийрэг, ирээдүйн иргэдийг бэлтгэх нь туйлаас чухал болоод байна. Монгол хүний эрүүл мэнд бол монгол төрийн бодлогоос ангид байх ёсгүй, төр болон иргэн бүрийн хамтын хичээл зүтгэлээр хамгаалах ёстой үндэсний үнэт баялаг билээ. Та бүхнийг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөнд улам ихээр идэвх санаачлагатай оролцохыг уриалж байна.



ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН БОЛ ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН САЛШГҮЙ ХЭСЭГ

*О.Баттулга,
Монгол Улсын Засгийн Газрын тохируулагч
агентлаг-Биеийн тамир,
спортын улсын хорооны дарга*



Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталж биеийн тамир, спортын салбарын зорилтыг “Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ гэж тодорхойлсон.

Монгол Улс хүнээ хөгжүүлэх, түүний дотор биеийн тамир, спортоор дамжуулан эрүүл, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, цаашлаад гэр бүлийг бий болгох талаар урт хугацааны хөгжлийн бодлогодоо тусгаж өнгөрсөн хугацаанд биеийн тамир, спортын салбар улсын хэмжээнд “Эрүүл мэндийн цахим гүйлт”, “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аян, “Цахим гимнастрада”, “Дасгал хөдөлгөөн хийцгээе” зэрэг томоохон арга хэмжээнүүд, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаар 2020-2022 онд 56 спорт заал, 113 гадна талбай ашиглалтад оруулан спортын хичээллэх ээлтэй орчин бүрдүүлэх зэрэг тодорхой ажлуудыг хийсэн бөгөөд 2023 онд биеийн тамир, спортын бүхий л үйл ажиллагаагаараа нийгэмд эерэг хандлагыг түгээх зорилгоор “Эерэг хандлага-Эрүүл нийгэм” аян, “Цаг гаргая” биеийн тамирын арга хэмжээг эхлүүлээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийтийн биеийн тамир, спортын онцгойлон анхаарч дээрх үйл ажиллагаануудтай уялдуулан ажиллаж байгаа нь биеийн тамир, спортын салбарын хөгжилд томоохон дэмжлэг болж, спортын хөгжлийн зорилтыг хангахад чухал нөлөө үзүүлнэ.

Монгол Улсын төр засаг, ард иргэд хамтран Спортын амжилтаа олимпын тавцанд гаргаж чадсантай нэгэн адилаар иргэн бүр өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэндэд анхаарал хандуулж, идэвхтэй хөдөлгөөн, спортоор тогтмол хичээллэхдээ цаг гаргаж, эерэг, зөв хандлага бүрдүүлсэн эрүүл нийгэм, идэвхтэй амьдралын хэвшил бүхий иргэн, гэр бүл бий болох уриалга дэвшүүлж байна.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО



Олон улсад халдварт бус өвчлөлийн тархалт хурдацтай нэмэгдэж, нас баралтын шалтгааныг тэргүүлж байна. Тус өвчлөл нь хүний амьдралын буруу хэв маяг, зан үйлээс үүдэлтэй бөгөөд сэргийлэх боломжтой.

Дэлхий даяар



НҮБ-ын **2030** он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтод халдварт бус өвчлөл (ХБӨ)-өөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх замаар “ХБӨ-өөс үүдэлтэй цаг бусаар нас барах явдлыг **2025** он гэхэд **25%**, хөдөлгөөний хомсдолыг **10%**-иар бууруулах”-аар зорилт дэвшүүлсэн.


Монгол Улсын эрүүл мэндийн статистик үзүүлэлтээс харахад хүн амын нас баралтын шалтгааны **85.9%**-ийг Халдварт бус өвчлөл эзэлж, үүний дотор **3** хүний **1** нь зүрх судасны тогтолцооны өвчин, **4** хүний **1** нь хавдрын улмаас нас барж байна.

ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН-ЭРҮҮЛ МЭНД

Таргалалт: эр-**17%**, эм-**21%**

Илүүдэл жин: эр-**48%**, эм-**51%**

Азийн зарим улсын спортоор тогтмол хичээллэгчдийн хувь



Спортоор хичээллэх боломжтой хүн амын тоо

2,804,187,0



Нийт боломж: 83.14%

2,331,325,0 хүн ам



Азийн дундаж: 60%

1,398,795,0 хүн ам

Зорилго: Азийн дунджид ойртох

“НИЙТИЙН ХӨЛБӨМБӨГ”

ТӨСЛИЙН ӨДӨРЛӨГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Хөл бөмбөгийн спортыг эх орондоо өргөн цар хүрээнд түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилгыг “8 жил, 8 зорилго” урт хугацааны төлөвлөгөөнийхөө нэгээхэн хэсэг болгон ажиллаж буй МХБХ “Нийтийн хөлбөмбөг”-ийн үйл ажиллагааг 2022 оны 5 дугаар сарын 8-18-ны хооронд “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх нээлтийн үйл ажиллагаанд оролцож “Хөлбөмбөгийг үндэсний спортын хэмжээнд хүртэл хөгжүүлэхэд тусалж дэмжих”-ээ илэрхийллээ.

Английн Арсенал Челси Тоттенхэм зэрэг томоохон клубүүдэд хүчин зүтгэж явсан ДАШТ-ийн мөнгөн медальт **ВИЛЛИАМ ГАЛЛАС** бидний урилгаар Нийтийн хөлбөмбөгийн арга хэмжээнд оролцсон нь нээлтийн гол үйл явдал байлаа.

Дэлхийн хамгийн олон хүнийг өөртөө дурлуулдагаараа хөлбөмбөг өөрөө гайхамшигтай спорт. Гайхалтай болгодог хүчин зүйл нь үзэгч хөгжөөн дэмжигчид бөгөөд МХБХ хөлбөмбөгийн хорхойтнуудаа дэмжиж ДАШТ-ийг үзүүлэхээр зорьж байгаа билээ. Тиймдээ ч “Voo”-тэй хамтран “Mobi premier” лигийн азтай үзэгчдэдээ Катар 2022 тэмцээний тоглолтуудыг үзэх эрхээр шагналаа.

Улсын төв цэгт ногоон талбай дэвсэж хөлбөмбөгийн спортын гоё сайханыг хүн бүрт түгээхийг зорьсон арга хэмжээнд Монгол Хөлбөмбөгийн Холбооны гишүүн клубүүд болон 21 аймгийн гишүүн холбоод өөрсдийн үйл ажиллагаагаа танилцуулахын зэрэгцээ, нийтийн хөлбөмбөгийн танилцуулга, тоглолтуудыг хийлээ.

Мөн Улаанбаатар хотын 9 дүүргийн аварга шалгаруулах “UB Cup 2022” тэмцээний шигшээ тоглолтууд Сүхбаатарын талбай дахь ногоон талбайд явагдав.

Монголын Хөлбөмбөгийн Холбоотой хамтран ажилладаг Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын харьяа аж ахуйн нэгжүүд 10 хоногийн арга хэмжээнд өөрсдийн асраа босгон оролцсон юм.

Хөлбөмбөгийн спортын шударга байдлыг хангахаар манай холбоотой хамтран ажилладаг “Авлигатай Тэмцэх Газар”-ын хамт олон тус арга хэмжээнд оролцож спорт бооцоо, тоглолт наймаалцахаас урьдчилан сэргийлэх уриалгыг дэвшүүлэв.





2.2 ЭРҮҮЛ ЗАН ҮЙЛ

Хүний өдөр тутмын амьдралын үйл ажиллагаан хэвшмэл, зуршил болсон үйлдлүүдийг зан үйл гэнэ. Эрсдэлт зан үйл гэдэг нь өвчин эмгэгт өртөмхий байдлыг нэмэгдүүлэх нөлөө бүхий зан үйлийн зарим хэлбэр, зуршлыг хэлдэг. ДЭМБ-аас зүрх судасны өвчнүүд, чихрийн шижин, хорт хавдар, архаг амьсгалын замын эмгэг, осол гэмтэл зэргээс урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой бөгөөд эдгээр нь тамхи татах, согтууруулах ундааны зохисгүй, аюултай хэрэглээ, хөдөлгөөний дутагдал, буруу хооллолт зэрэг хувь хүний эрсдэлт зан үйлээс ихээхэн хамаардаг байна. Өвчин эмгэгт хүргэдэг эрсдэлт хүчин зүйлийг өөрчлөх боломжтой ба өөрчлөх боломжгүй гэж хувааж үзэж болно. Өөрчлөх боломжтой эрсдэлт хүчин зүйлд архины хортой хэрэглээ, тамхи татах, хөдөлгөөний дутагдал, жимс хүнсний ногоо хангалтгүй хэрэглэх, илүүдэл жин, даралт ихсэлт зэрэг ордог тул “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь эдгээр эрсдэлийг бууруулах нийтийн эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэж байна.




ЗОРИЛТ:

Хүн амын дундах архи согтууруулах ундаа, тамхины хэрэглээг бууруулах эрх зүйн орчныг сайжруулах, Эрүүл зөв хэрэглээг төлөвшүүлэх цогц нөлөөллийн ажлыг явуулах

- 6.3.1** Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, тамхины хяналтын хуулийн хэрэгжилтийг судлах, өөрчлөх хэрэгцээг судалгаанд суурилан боловсруулах, хуульд өөрчлөлт оруулах чиглэлд хамтран ажиллах
- 6.3.2** Хүн амын бүлгүүд, үйлчилгээний салбарт чиглэсэн соён гэгээрүүлэх, шинэ соёл, дадлыг төлөвшүүлэх интервенцийг тасралтгүй зохион байгуулах
- 6.3.3.** Донтох эмгэгийн үеийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх





МОНГОЛЧУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:



Нас баралт:
Жилд **16.5 мянга**



61% эр
39% эмэгтэй



Дундаж наслалт:



Эрэгтэй
66.7



Эмэгтэй
76.2



Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр архи хэтрүүлэн хэрэглэсний улмаас дэлхийд **1** жилд **2.8-3** сая, өөрөөр хэлбэл, **1** минутад **6** хүн нас барж байна.

Дэлхийн дахинд **107** сая орчим хүн архины хамаарал бүхий эмгэгтэй байгаагийн **70** хувь буюу **75** сая нь эрэгтэй, **32** сая нь эмэгтэй байна.

Дэлхийн хүн амын эрүүл мэндийн ачааллыг (GBD) тооцдог Эрүүл мэндийн хэмжилт, үнэлгээний хүрээлэнгийн (IHME) тооцооллоор Монгол хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх **5** эрсдэлт хүчин зүйлд цусны даралт ихсэх, зохисгүй хооллолт, тамхи, архины хэрэглээ, илүүдэл жин- таргалалт орсон байна.

Архины хортой хэрэглээ нь маш олон өвчний эрсдэлт хүчин зүйл болдог. Тухайлбал элэгний хатуурал, нойр булчирхайн үрэвсэл, элэгний хавдар гэх мэт. Архины зохисгүй хэрэглээний шууд ба шууд бус нөлөөллийн улмаас **200** гаруй эмгэг үүсдэг

Согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой эмгэгийн тархалт Монгол улсад **4.44** хувь байгаа нь дэлхийн дундаж (**1.4%**)-иас **3** дахин их буюу дэлхийд эхний байранд байна.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний чухал бүрэлдэхүүний нэг нь эрүүл зан үйл, ялангуяа согтууруулах ундаа, тамхины хэрэглээг бууруулах, зөв дадал, зуршилтай иргэнийг бид цэцэрлэг, сургуулиас нь төлөвшүүлэх нь чухал. Согтууруулах ундааны шалтгаант эмгэгийн тархалт, цаг бусын нас баралтаар манай улс дэлхийд тэргүүлж байна, насанд хүрсэн 1 хүнд ногдох хатуулаг өндөртэй архины хэмжээ тасралтгүй өссөөр байна. Зөвхөн архи, тамхины шууд ба шууд бус нөлөөний улмаас жилд 8000 орчим иргэн амь насаа алдаж байгаа нь нийт нас баралтын 50 орчим хувийг эзэлж байна. Эндээс харахад өвчин хийсэж биш хэлж ирдэг, та бидний зуршил, зан үйл, дадлаас хамаарч байна. Олон сайхан залуус архины зохисгүй хэрэглээнээс үүдэн амь насаа алдаж, эрх чөлөөгөө хязгаарлуулж, гэр бүл салж, хүүхэд эрсдэж, гэмт хэрэг зөрчлийн дийлэнх нь энэ согтууруулах ундаанаас хамаарч байна.

Сүүлийн 30 жилд дотоодод 120 сая литр архи, согтууруулах ундаа үйлдвэрлэж, нийлүүлж байгаа нь насанд хүрсэн нэг хүнд 54 литр ноогдож байна. Согтууруулах ундаагаар үйлчилгээ хязгааргүй тэлж 10000 иргэнд Улаанбаатар хотод 103, харин аймгуудад 52 согтууруулах ундааны цэг ноогдож

байгаа нь архи худалдан авах, хэрэглэх боломжийг иргэдэд ойртуулж, маш их хүртээмжтэй байгааг харуулж байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний чуулганд архины хэрэглээ 30 дахин өсөж түүний шалтгаант эмгэг 40 дахин нэмэгдсэн хэмээн судлаачид онцолжээ. Архинд донтох, хэтрүүлэн хэрэглэх нь эмчилгээ, тусламж шаарддаг бие даасан өвчин. Үүнийг эмчилдэг нөөц хир байгааг дурьдмаар байна. 10 000 иргэнд ноогдох сэтгэцийн эмч ердөө 0.4 харин наркологийн эмч 0.06 ноогдож байгаа нь архины шалтгаант эмгэгээс сэргийлэх, үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж үзүүлэх боломж бүрдээгүй, иргэд тусламж авч чадахгүй байна.

Дэлхийн улс орнуудын сайн туршлагаас харахад согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлахад хамгийн түрүүнд татварын Эрүүл зөв бодлого, үнийн өөрчлөлт, тодорхой сегментэд чиглэсэн интервенц үр дүнгээ өгдөг. Иймд архинд ноогдуулах Онцгой албан татварын тооцоолол, түүний эрүүл мэнд, эдийн засгийн үр нөлөөг олон хувилбараар тооцож, түүнд тулгуурлан 2022 оны 4 сарын 5-ны өдөр Ерөнхийлөгчийн 43 тоот зарлиг гарсан.



Монгол Улсын Ерөнхийлөгч архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулах талаар зарлиг гаргалаа
2022.04.05



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр

Дугаар 43

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Нэг. Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор “Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн хүрээнд “Эрүүл Монгол Хүн” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг хангах үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар(Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай:

1.1.Архи, согтууруулах ундааны Эрүүл зөв хэрэглээг төлөвшүүлэх, өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах чиглэлд бодлогын болон эрх зүйн өөрчлөлт хийх;

1.2.Онцгой албан татварын ангилал, шатлалд өөрчлөлт оруулах замаар 38 хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааны хатуулгийг 10 жилийн хугацаанд жил бүр 2 хувиар бууруулах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх;

1.3.Архи, согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварын орлогоос хавдрын эмнэлэг, донтох өвчнийг эмчлэх төв болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг байгуулах, архи согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлд зарцуулах;

1.4.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох;

1.5.“Халамжаас хөдөлмөрт” шилжих суурь шинэтгэлийн хүрээнд ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

1.6.Архи, согтууруулах ундааны хууль бус үйлдвэрлэл, борлуулалттай тэмцэх арга, хэлбэрийг боловсронгуй болгох, цахим техник, технологид суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүнд оногдуулах эрүүгийн болон зөрчлийн ял шийтгэлийн бодлогод өөрчлөлт оруулах;

1.7. Хорт зуршлаас ангид шинэ үеийг төлөвшүүлэх хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт архи, согтууруулах ундаа, түүнээс үүдэн гарах хор уршиг, сөрөг нөлөөг сурталчлан таниулах агуулгыг тусгах;

1.8.Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;

1.9.Согтууруулах ундааны шошгон дээр согтууруулах ундааны хор уршиг, сөрөг нөлөөний талаарх анхааруулга, санамж байршуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Хоёр. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.

Гурав. Энэхүү зарлигийн хэрэгжилтийн явцыг олон нийтэд цаг тухай бүр мэдээлж, тайлан мэдээллийг Монгол Улсын Ерөнхийлөгчид жил бүр ирүүлж байхыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ

ЗАРЛИГИЙН ХЭРЭГЖИЛТ

1.1. Архи, согтууруулах ундааны Эрүүл зөв хэрэглээг төлөвшүүлэх, өнөдөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах чиглэлд бодлогын болон эрх зүйн өөрчлөлт хийх

Монгол Улсын Их Хурал 2022 оны 07 дугаар сарн 19-ний өдөр Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ хууль болон дагалдах хуулиудыг баталсан билээ. Уг хууль нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөнө.

1.2. Онцгой албан татварын ангилал, шатлалд өөрчлөлт оруулах замаар 38 хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааны хатуулгийг 10 жилийн хугацаанд жил бүр 2 хувиар бууруулах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж тус хуулийн 6.11 дэх хэсэгт бүх төрлийн цагаан архи, ликёр, кордиал ба спиртлэг бусад ундаа болон бүх төрлийн коньяк, виски, ром, джинд дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулахаар хуульчилсан.

Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл		Биет нэгж	2023 оны 01 дүгээр сарын 01-нээс 2025 оны 01 дүгээр сараас 01 хүртэл	2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 2027 оны 01 дүгээр сараас 01 хүртэл	2027 оны 01 дүгээр сарын 01-нээс 2029 оны 01 дүгээр сараас 01 хүртэл	2029 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш
Бүх төрлийн цагаан архи, ликёр, кордиал ба спиртлэг бусад ундаа	25 хүртэл хатуулагтай	1 литр	3700	3900	4100	4300
	25-26 хүртэл хатуулагтай	1 литр	7300	7700	8100	8500
	26-28 хүртэл хатуулагтай	1 литр	7300	7700	8100	8500
	28-30 хүртэл хатуулагтай	1 литр	7300	7700	8100	8500
	30-32 хүртэл хатуулагтай	1 литр	7300	7700	8100	10440
	32-34 хүртэл хатуулагтай	1 литр	7300	7700	8100	13050
	34-36 хүртэл хатуулагтай	1 литр	7300	10440	11500	12600
	36-38 хүртэл хатуулагтай	1 литр	10440	11500	12600	13800
	38-40 хүртэл хатуулагтай	1 литр	10440	11500	12600	13800
	40 ба түүнээс дээш хатуулагтай	1 литр	31300	34450	37900	41690

1.3. Архи, согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварын орлогоос хавдрын эмнэлэг, донтох өвчнийг эмчлэх төв болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг байгуулах, архи согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлд зарцуулах

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан нээсэн. Тус хуулийн 213 дугаар зүйлд заасны дагуу уг сан нь архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай байна.

Онцгой албан татварын тухай хуулийн 6.11-д заасны дагуу ногдуулан хураасан татварын орлогын гүйцэтгэлээс татвар ногдсон согтууруулах ундааны литр тутам хамаарах 300 төгрөгийн орлогыг Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих санд тухай бүр төвлөрүүлнэ



Эрүүл мэндийг дэмжих гэж юуг хэлэх вэ?

Өөрийнхөө эрүүл мэндийг хянан, сайжруулахын төлөө гэр бүл, хамт олноороо хийж чадах зүйлээ нэмэгдүүлэх, эрүүл аж төрөх зан үйлийг дэмжих, боломж олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа



1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд Төрийн ёслол, хүндэтгэлийн гадаад арга хэмжээг зохион байгуулахаас бусад тохиолдолд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглохоор хуульчилсан.





СЭТГЭЛ БОЛ ЭРХТЭН

*Р.Энхтүвшин,
АШУУИС, СЭМТ-ийн багш,
Сэтгэл заслын эмч*



Аливаа асуудлыг хүн бүр өөр өөрөөр хүлээж авдаг бөгөөд сэтгэцийн хувьд нэг хэсэг нь төрөлхийн мэдрэмтгий хүмүүс бусдаас илүү санаа зовнидог. Бид сэтгэцийн асуудал ярихын тулд Сэтгэл гэж юу вэ гэдэг талаар ойлгох нь чухал. Зүрх сэтгэл, сэтгэл санаатай хүн, сэтгэлийн тэнхээтэй байгаарай, сэтгэлийн хүч, сэтгэл санаа тайван байна гэхчлэн бид байнга л сэтгэл гэдэг зүйлийн талаар ярьж, сонсдог мөртлөө сэтгэл гэж юу байдаг талаар бодож үзсэн хүн цөөн байдаг. Нүдэнд харагдахгүй, гарт баригддаггүй, тэгсэн мөртлөө өдөр бүр бидний амны уншлага, ярианы сэдэв болдог энэ зүйл ер нь юу юм бол. Бид сэтгэлийн амьтан мөн юм болтэр сэтгэл гээч нь хаана байгаа юм бол оо. Магадгүй нэг зүйлийг анзаарахад сэтгэл гэдэг үг хайр, зүрх гэдэг үгнүүдтэй холбоотой яригдах нь элбэг. Хайр сэтгэл, зүрх сэтгэл гээд сонсохоор өөрийн эрхгүй биднийг сэтгэл хөдлөлтэй холбоно. Тэгэхээр СЭТГЭЛ хөдлөлийг үүсгэдэг эрхтэн юм болов уу гэлтэй. Тэгвэл сэтгэл хөдлөл зөвхөн хүнд байдаг уу гэхээр үгүй. Амьтанд ч бас байдаг. Та сэтгэл сайтай амьтан, хайр сэтгэлээрээ холбогдсон муур, хөөрхий сэтгэл нь хөрчихсөн үхэр гэж сонсоогүй байх. Энэ нь юугаараа ялгаатай байдаг вэ гэхээр амьтанд ч сэтгэл хөдлөл бий ч энэ нь доод түвшний байдагтай холбоотой. Харин хүмүүн төрөлхтөн бид дээд зэргийн сэтгэл хөдлөлтэй, тэр нь нийгмийн агуулгатай буюу нийгмийн шинж чанартай байдаг. Сэтгэл хөдлөл нь бас дангаараа сэтгэл гэдэг “эрхтэнг” илэрхийлэхэд хангалтгүй байдаг нь хүний сэтгэхүйн үйл ажиллагаа үүнд бас оролцдог болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл сэтгэл хөдлөлөө ухаарах, ухамсарлах аваас сэтгэл гэдгийг бүтэн болгох юм. Дээрхийг дүгнэвэл хүн гээч бид дээд сэтгэл хөдлөлтэй, тэр нь нийгмийн агуулгатай, ухаарсан хэлбэртэй байдаг учир биднийг сэтгэлийн амьтан гэж нэрлэдэг. Хэн нэгнээс “Танд сэтгэл байдаг уу?” гэж асуувал бүгд л байдаг гэж хариулах нь лавтай. Үгүйсгэх хүн тун цөөхөн. Тэгвэл бид нүдэнд харагддаггүй, гар баригддаггүй ч сэтгэл гэдэг хийсвэр юм шиг хэрнээ бодит оршдог нэгэн ЭРХТЭН-тэй юм байна гэдгээ мэдэж авлаа.

Тэгвэл энэхүү эрхтнийг судалж, мэдэж, ойлгохын тулд учир нь унд оршдог бол? Бидний сэтгэл гэдэг эрхтэн бас бусад эрхтнүүдийн адил өвддөг, хугардаг, үрэвсдэг, шархалдаг юм байна. СЭТГЭЛ өвддөг учраас л бид нүднийхээ чийгийг аньсгандаа хадгалж чаддаггүй уйлдаг байх.

Бид хөлөө хугалчихвал гэмтлийн эмчид үзүүлдэг, зүрх минь өвдвөл зүрхний эмчид үзүүлдэг, халдварт өвчин тусвал халдвартын эмчээс зөвлөгөө авдаг, хүүхдүүд минь өвдвөл хүүхдийн эмчид ханддаг шүү дээ. Тэгвэл СЭТГЭЛ чинь өвдвөл, хугарвал, үрэвсэл хаанаас ямар тусламж авдаг бол? Олон хүн энэ асуултад өөр өөрийн өнцгөөс хариулдаг. Зарим нь ээж, аав дээрээ очдог, зарим нь найз нөхөдтэйгөө хуваалцдаг, зарим нь сүсэг бишрэлдээ даатгадаг, үлдсэн хэсэг нь хэн дээр ч очдоггүй, дотроо хадгалдаг гэдэг.





ЭДГЭШГҮЙ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ МИНИЙ ХҮСЭЛ

*Б.Мөнхсүлд,
Баянхонгор аймаг дахь “Жаргалтай амьдрал”
сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний
төвийн сэтгэцийн эмч*

Уншигчдадаа энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг Батжаргал овогтой Мөнхсүлд гэдэг. Миний бие 2009 онд Баянхонгор аймгийн “Номундалай цогцолбор” сургуулийг, 2015 онд АШУҮИС-ийг Хүний их эмч мэргэжлээр, Мөн 2018 онд АШУҮИС-ийг Сэтгэцийн эмч мэргэжлээр тус тус төгссөн. 2019 оноос Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн эмчээр ажиллаж эхэлсэн. Аймгийн нэгдсэн эмнэлэгт ажиллаж эхэлсэн цагаас Архинд донтох эмгэгтэй иргэдэд хордлого тайлах, оюун санааны эмчилгээг нэвтрүүлсэн. Анх тухайн үеийн аймгийн засаг дарга Г.Батжаргал, Нэгдсэн эмнэлгийн дарга Н.Баттогтох, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ийн захирал н.Тамжидмаа нарын дэмжлэгтэйгээр 10 иргэнд, мөн 14 сумаас 1 иргэнийг сонгон сэтгэл зүйн болон донтох эмгэгийн эмчилгээнд хамруулсан. 2021 оны 8 дугаар сард аймгийн шинэ засаг дарга Д.Мөнхсайхан, Цагдаагийн газрын дарга Б.Оюутболд нар дэмжин, хамтын шийдэл гарган “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийг байгуулсан.



2020 оны 08 дугаар сард аймгийн хэмжээнд “Сархадаас сална аа хө” аяныг зохион байгуулж, 5000 гаруй иргэдэд архинд донтох эмгэг ба Сэтгэцийн эрүүл мэндийн талаар сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Одоогоор тус аяны хүрээнд 15 000 гаруй иргэдэд сургалт нөлөөллийн ажил хийгдсэн байна. Ингээд аяны нөлөөллийн арга хэмжээ дуусах дөхөх үед буюу 2020 оны 10 дугаар сарын 5-ны өдөр Жаргалтай амьдрал төв нээлтээ хийсэн ба анх 6 хүний бүрэлдэхүүнтэй, 14 ортойгоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Энэ цагаас хойш 3 жилийн хугацаанд нийт 360 иргэнд донтох эмгэгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Одоогоор 40 орчим хувь иргэдийн архинд донтох эмгэг намжмал байдалд шилжиж, эмнэлгийн хяналтад байна.

Өнөөдрийг хүртэл нийт 500 гаруй иргэдтэй ажиллаж, архинд донтох эмгэгийн асуудлыг шийдвэрлэх гэж оролдлого хийх бүртээ тэдний гэр бүл ямар их шаналж, зовж байдгийг зүрх сэтгэлээрээ мэдэрч харуусан суудаг. Сүүлийн үеийн мэдээллээр 93 000 иргэн байгаа гэж байгаа боловч түүний ард нууц хэдэн хүн байгааг бид үл мэднэ. Мөн тэдний ард хэдэн мянган хэдэн сая иргэний сэтгэцийн эрүүл мэндийн асуудал яригдаж байна. Эцэст нь хэлэхэд шаардлагатай иргэн бүрт энэ төрлийн тусламж үйлчилгээг авах таатай нөхцөлийг бүрдүүлэх, сайхан цагийг хүлээн төрдөө зүтгэж байна. Алдаа бүхний цаана ухаарал хүлээж байдаг.





2.3 ЭРҮҮЛ ЗӨВ ХООЛЛОЛТ

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний үйл ажиллагааны нэгэн үндсэн бүрэлдэхүүн нь эрүүл, зөв хооллолт болно. Эрүүл, зөв хооллолт гэдэг нь хүний бие махбодын бодисын солилцооны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай шим тэжээллэг, аюулгүй хоол, хүнсийг тохируулан хэрэглэхийг хэлнэ.



АЛСЫН ХАРАА:

Амьдралын зөв хэв маягийг төлөвшүүлж, эрүүл хүн, гэр бүл, хамт олон бий болгоход оршино.



ЗОРИЛГО:

Хүн амын хоол шим тэжээл болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудлыг хөгжлийн урт болон богино хугацааны бодлоготой уялдуулж, шинжлэх ухаанч мэдлэг хандлага, зөв хэрэглээ бүхий дадлыг дээшлүүлснээр иргэдийн эрүүл мэнд, амьдралын чанарыг сайжруулна.



ЗОРИЛТУУД:

1. Нийт иргэдэд зөв хооллолт, хоол хүнсний зөв хэрэглээг таниулах, соён гэгээрүүлэх
2. Нийгэмд эрүүл, зөв хооллолт, дасгал хөдөлгөөнийг ач холбогдлыг сурталчлах, нутагшуулах зорилгоор богино хугацааны зорилтот хөтөлбөр хэрэгжүүлж, үр дүнг нийтэд сурталчилж, нийгэмд эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх
3. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт аюулгүй байдлыг хангах, стандартжуулах тогтолцоо бүрдүүлэх, эхлүүлэх
4. Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний систем бий болгох ажлыг түүчээлэн загвар төсөл хэрэгжүүлэх

Эрүүл, зөв хооллолтод нөлөөлөх хүчин зүйлс



ХҮРЭХ ҮР ДҮН:

Хүлээгдэж буй үр дүн

- Иргэдийн хоол, хүнсний талаар мэдлэг дээшилж, эрүүл, зөв хооллох хандлага, дадал дээшилсэн байна.
- Байгууллага, хамт олон өөрсдийн эрүүл, зөв хооллолт, дасгал хөдөлгөөний хосолсон хөтөлбөрийг түүчээлэн хамгийн багадаа 50 байгууллага өөрийн хөтөлбөртэй болж, нутагшуулсан байна.
- Төрийн өмчийн цэцэрлэг, сургуулийн 50% нь стандартын шаардлага хангаж, тохирол авсан байна. Төрийн өмчийн 30 сургуулийн үдийн хоолны үйлчилгээ шаардлага хангах түвшинд хүрч, жишиг загвар болсон байна. Бүх сурагч хоолны үйлчилгээнд хамрагдахын сацуу багш, ажиллагсадын үдийн хоолны тулгамдсан асуудал шийдэгдэнэ.
- Төрийн худалдан авалтын тогтолцоонд сургууль, цэцэрлэгт нийлүүлэгдэж буй гол нэрийн 3-5 хүнсний бүтээгдэхүүн хамрагдсан байна.



ХҮН АМЫН ХООЛ, ШИМ ТЭЖЭЭЛИЙН БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТҮВШИНГ ДЭЭШЛҮҮЛЭХ АНХДАГЧ БОЛОМЖ

*М.Пүрэвжав,
ШУТИС, УТС-ийн ЭнБД, дэд профессор*

“

Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах нь олон хүчин зүйлээс шалтгаалах хэдий ч үндсэн хүчин зүйл бол хүн амын хооллолт юм. Хооллолт гэдэг нь өдөр тутмын хоолоор авч буй шим тэжээлийн Эрүүл зөв харьцаа бүхий хэмжээгээр илэрхийлэгдэх бөгөөд байгалийн гурил, тариа, ногоо, бэлчээрийн малын мах, сүү тэргүүтэн ойр байдаг манай улсын хувьд хүн ам нь эрүүл хүнсээр хангагдах бүрэн боломжтой.

Өөрөөр хэлбэл, хүнсний хангамж, хүртээмж нь түлхүүр асуудал бөгөөд дотоодын чанартай, хямд, найдвартай хүнсний хангамжийн тогтолцоо бүрдэх нь чухал юм. Үнэхээр манай хүнс чанартай юм бол өөрсдийгөө эхлээд «хооллох» ёстой, энэ нь ирээдүйд “ЭРҮҮЛ ХҮН” гэх асар үнэт нийгмийн баялгийг бий болгох болно. Ялангуяа хүүхдийг эхийн хэвлийд бий болох цагаас 18 нас хүртэл зөв хооллож, шим тэжээлийн тэнцвэртэй байлгаж чадвал эрүүл иргэн өсөн бойжино, улмаар нийгэм, эдийн засгийн хувьд үнэлж барамгүй үр өгөөжтэй гэдгийг дэлхийн улс бүр анхаарч төрийн бодлогодоо уяж байна. Эдгээрийн талаарх баримт, мэдээлэл хаа сайгүй...

Эрүүл төрсөн хүмүүний насан туршдаа эрүүл орших үндсэн нөхцөл нь бага наснаас нь зөв хооллох асуудал мөн тул цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг анхаарч байна. Хүн амын өдөр тутмын хооллолт уламжлалаа хадгалсан, хоолзүйн шинжлэх ухаанд суурилсан маш энгийн байх нь үр дүнтэй бөгөөд өндөр хязгаарлалт бүхий хоолны дэглэм, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зар сурталчилгаа, шинжлэх ухаанч бус буруу ойлголт, түүнд хариу өгөх мэргэжлийн тогтолцоогүй байж болохгүй юм.

Үүнээс ангижрах арга зам бол аливаа хүнд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох явдал бөгөөд үүнд “Хоолзүйн боловсрол” багтана. Асар их мэдээлэл, бизнес хөгжлийн эрин зуунд хүнийг хамгаалах хэрэгсэл нь боловсрол бөгөөд хоолзүйн боловсролыг хэдий сайн өгнө төдий чинээ нийгмийн болоод хувь хүний эдийн засаг, эрүүл мэнд, амьдралын чанарт эерэгээр нөлөөлөх болно.



Монгол хүний өвчлөл эндэгдлийн тэргүүлэх шалтгаан болж буй зүрх судасны өвчний 80 хувь, чихрийн шижингийн 90 хувь, хорт хавдрын тохиолдлын 30 хувь нь хоол хүнсний зохисгүй хэрэглээ, тухайлбал өөх тос, давс, чихрийн хэт их хэрэглээ, микро-макро шимт бодисын дутал, жимс хүнсний ногооны хязгаарлагдмал хэрэглээ зэргээс шалтгаалж байна.

Зохисгүй хооллолт, хөдөлгөөний дутал, буруу зан үйлээс хамаардаг эрсдэлийн тархалтын өнөөгийн байдал



Хоол хүнсний илчлэг чанар нь түүнд агуулагдах үндсэн шимт бодисын хэмжээгээр тодорхойлогдоно. Өөх тос, чихэр, давсыг хэтрүүлэн хэрэглэх нь хүний эрүүл мэндэд эрсдэлтэй:

Монгол улсын 15-69 насны хүн амын жимс, хүнсний ногооны хоногийн дундаж хэрэглээ 3.2 нэгж, үүнээс жимс 0.9 нэгж, хүнсний ногоо 2.3 нэгж хэрэглэж байгаа нь ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс доогуур хэвээр байна. Хүн амын дийлэнх хэсэг (83.4%) нь ДЭМБ-ын зөвлөмж болох "хоногт 5 нэгж"-ээс бага жимс, хүнсний

ногоо хэрэглэж, үүнээс хөдөө, орон нутгийн хүн амын жимс, хүнсний ногооны хэрэглээ хот, суурин газрын хүн амаас 1.5-3.2 дахин бага байна.

Хүн амын давсны дундаж хэрэглээ 10.5г байна. Монголчуудын давсны хэрэглээг 2013 онтой харьцуулахад 0.6г-аар, мөн Баруун бүсэд 5.1г, Улаанбаатарт 1.2 г-аар тус тус буурсан хэдий ч ДЭМБ-ын зөвлөмжөөс 2 дахин их хэвээр байна. Хүн амын давсны хэрэглээ Хангайн бүсэд 1.1г, Төвийн бүсэд 0.7г, Зүүн бүсэд 2.9г болж тус тус нэмэгдсэн, давсны хэрэглээний талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадал, түүнчлэн өөрийн давсны хэрэглээг бууруулах, хянах байдал Төвийн бүс, Зүүн бүсэд хангалтгүй байгаа нь цаашид эдгээр бүс руу чиглэсэн арга хэмжээ шаардлагатайг харуулж байна.

Өөх тос-Хүн амын дийлэнх буюу 87.2% нь гэртээ хоол хүнс бэлдэхдээ голчлон ургамлын тос хэрэглэж байна. Хоол хүнс бэлдэхдээ голчлон дотор өөх, гахайн тос, эсвэл цөцгийн тос, шар тос хэрэглэдэг хүн амын тархалт хөдөө орон нутагт харьцангуй өндөр байв.

Хүн ам 7 хоногт дунджаар 1.8 удаа гэртээ бэлдээгүй хоол хүнс идсэн байна. Гадуур хооллох давтамж хүн амын хүйс ба байршлаар ялгаатай, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.3 дахин, хот суурин газрын хүн ам хөдөө орон нутгийнхнаас 2.9 дахин олон удаа гэрээс гадуур хооллож байв.

Улс орон бүрд нийтийн танил дүрсээр илэрхийлэгдэх хооллолтын зурагт зөвлөмж байдаг бөгөөд манай улсад гэр зөвлөмж 20 гаран жил болж, 3 удаа шинэчлэгдээд байна. Иргэн бүр бага наснаас энэхүү зурагт зөвлөмжийг мэддэг, хэрэгжүүлдэг байх ёстой боловч манай улсад зурагт зөвлөмж зураг төдий байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

Нөгөө талаар зөв хооллолтыг хэрэгжүүлэхэд хэдий сайн хүнс олдоцтой байсан ч тухайн хоол хүнсийг хэзээ, ямар хэмжээгээр, хэрхэн боловсруулж хэрэглэж байгаа нь шийдвэрлэх нөлөө үзүүлдэг.

ХООЛ, ХҮНС

Тэжээллэг, аюулгүй хүнсийг тогтмол, тохируулан зөв хэрэглэснээр хоол, хүнснээс үүдэлтэй өвчин, эмгэгээс сэргийлэх, улмаар хөдөлмөрийн бүтээмж, оюуны чадамж өндөр байж, амьдралын чанар сайжирна.

Хүн хоногийн хоолондоо 6 бүлэг хүнсийг тэнцвэртэй хэрэглэж, өөрт шаардлагатай шим тэжээл болон илчлэгээ нөхөх ёстой.



ҮҮНД:

1

ҮР ТАРИА, ГУРИЛ, БУДАА:

Энэ бүлэгт бүх төрлийн будаа, гурил, түүгээр хийсэн бүтээгдэхүүн болон төмс орох ба бүхэл үрийн гурил, будаа, түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг сонгож хэрэглэвэл ашигтай. Харин дээд гурилаар хийсэн нарийн боов, жигнэмэг зэрэг нь энгийн нүүрс ус ихээр агуулахын зэрэгцээ тос, чихэр ихээр агуулдаг тул хязгаарлах шаардлагатай.



2

ЖИМС, ЖИМСГЭНЭ:

Жимс, жимсгэнэ нь бүх төрлийн аминдэм, эрдэс болон биологийн идэвхит бодисуудын эх үндсэн эх үүсвэр болдог.



3

ХҮНСНИЙ НОГОО:

Хүнсний ногоо нь нүүрс ус, эслэг, А, С, Р, К, В-ийн төрлийн аминдэм, магни, төмөр, иод, селен, кобальт, кальци зэрэг эрдэс бодисын үндсэн эх үүсвэр болох ба биеийн эсэргүүцэл сайжруулах, гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг сайжруулж өтгөн хатах, ходоод гэдэсний өвчлөлөөс сэргийлэхэд чухал нөлөөтэй.



УУСДАГ ЭСЛЭГ: Жимс, жимсгэнэ, арвай, буурцагт ургамалд агуулагддаг. Энэ эслэг нь Гельд төст бодис ба гэдэсний ашигтай бактерийн өсөлтийг дэмждэг. Цусны сахар, холестеринийг бууруулж судас хатуурах өвчнийг 50% бууруулдаг.

УУСДАГГҮЙ ЭСЛЭГ: Ногоо, үр тарианы тарианы хальсанд байх ба хоол боловсруулалтыг дэмжих, гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг сайжруулах, өтгөн хаталтаас сэргийлдэг.

4

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН:

Үл орлогдох амин хүчил, ханасан тос, аминдэм А, В, Д, кальци, цайр, фосфор, магни зэрэг эрдэс бодисын эх үүсвэр болж, ясны өсөлт, шүдний бат бэх чанарт нөлөөлөхөөс гадна булчингийн үйл ажиллагаанд оролцдог.



5

МАХ, УУРАГЛАГ ХҮНС:

Малын мах, шувуу, гахай, загасны мах, дотор мах, өндөг, шош, вандуй, самар энэ бүлэгт ордог. Мах нь уургаар баялаг гол бүтээгдэхүүн бөгөөд хүний биед үүсдэггүй үл орлогдох биологийн төгс амин хүчил / уураг/, төмөр, фосфор, натри, кали зэрэг нэн шаардлагатай эрдэс бодисууд болон А, Е, Д, К аминдэмийг агуулдаг.





ЧИХЭРЛЭГ УНДААНЫ ЗОХИСГҮЙ ХЭРЭГЛЭЭ ЭРС НЭМЭГДЛЭЭ

*М.Ундрам,
АУ-ны доктор, АШУУИС, АУС багш*



Дэлхий дахинд хүн амын чихэрлэг ундаа, хүнсний хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа бөгөөд бага болон дунд орлоготой иргэдийн энэ төрлийн ундааны хэрэглэх нь улам бүр нэмэгдэж байгаа нь хотжилт, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой байна. Чихэрлэг ундааг тогтмол хэрэглэснээр жингийн илүүдэл, 2-р хэлбэрийн чихрийн шижин, зүрх судасны өвчин (ЗСӨ), зарим төрлийн хорт хавдраар өвчлөх эрсдэл нэмэгддэг бөгөөд дэлхийн улс орнууд энэхүү бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах төрөл бүрийн бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Дэлхий даяар илүүдэл жин, таргалалтын тархалт сүүлийн 40 жилийн хугацаанд бараг гурав дахин нэмэгдсэн нь 21-р зууны нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Дэлхийн өнцөг булан бүрийн хүн амд суурилсан судалгаагаар таргалалтын тархалт 1975-2016 оны хооронд хүүхдүүдийн дунд 1 хувиас 6-8 хувь болж өссөн бол насанд хүрсэн эрэгтэйчүүдэд 3-11 хувь, эмэгтэйчүүдийн дунд 6-15 хувь хүртэл өссөн байна. Дэлхийн хүн амын 30 орчим хувь буюу 2.1 тэрбум гаруй хүн илүүдэл жинтэй буюу таргалалттай байгаа нь эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн томоохон зардлыг үүсгэж байна. Таргалалтын дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө нь ойролцоогоор 2 их наяд ам.доллар буюу дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувьтай тэнцэж байгаа нь тамхи, зэвсэгт мөргөлдөөний улмаас дэлхийн эдийн засагт учруулж буй сөрөг үр дагавартай бараг дүйцэхүйц хэмжээтэй байна гэж судлаачид тодорхойлжээ.

Бид 2017 онд чихэрлэг ундааны зах зээлийн ба онцгой татварын тооцооллын судалгаа, 2018-2019 онд хүүхэд, өсвөр үеийнхний илүүдэл жин, таргалалтад үзүүлэх чихэрлэг ундааны нөлөөллийн судалгаа, 2022 онд Монгол улсын хүн амын чихэрлэг ундааны хэрэглээний судалгааг тус тус хийж гүйцэтгэсэн. Монгол улсын хувьд, нэг хүнд өдөрт 367 мл, сард 11.1 л чихэрлэг ундаа ногдож байгаа нь зөвхөн түүнээс авч буй чихрийн хэмжээ зөвлөмж хэмжээнээс даруй 3 дахин ихсэхэд хүргэж байна. 2022 онд Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр бидний хийсэн судалгаагаар өсвөр насныхны 50.3 хувь чихэрлэг ундааг дунджаас дээш болон их хэмжээгээр хэрэглэдэг, 65% нь тогтмол буюу 7 хоногт 1-ээс олон удаа уудаг, долоо хоногт чихэрлэг ундаанаас авч буй нийт нүүрсусны хэмжээ охид, хөвгүүдэд ойролцоо буюу 555 гр-аас 655 гр байв. Улаанбаатар хотын өсвөр насныхны долоо хоногт чихэрлэг ундаанаас авч буй нүүрсусны хэмжээ 838 гр, орон нутагт 521 гр байлаа. Насанд хүрэгчдийн хувьд 41.2% нь гэр ахуйн орчинд, 36.4% ажил эсвэл сургуулийн орчинд харин 17.7% нь баар, ресторан гэх мэт олон нийтийн үйлчилгээний газруудад чихэрлэг ундааг голлон хэрэглэдэг байна. Хүн амын ЧУ-ны хэрэглээг өөрчлөхийн тулд бүх нийтийг хамарсан эрүүл мэндийн боловсрол олгохын зэрэгцээ бодлогын олон аргыг засаглалын янз бүрийн түвшинд хослуулан хэрэгжүүлэх нь чухал болохыг олон улс оронд хийгдсэн судалгааны үр дүнгүүд харуулж байна. Судлаач бидний болон бодлого боловсруулагчдын хувьд нэн тэргүүний зорилт бол нэгэнт хэвшээд буй зан үйлийг аль болох богино хугацаанд өөрчлөх хэрэгжихүйц, хэмжигдэхүйц бодлогуудыг хэрэгжүүлж, үр дүнг тогтмол хугацаанд хэмжиж, практикт ашиглах нь чухал байна.

2.4 ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний чухал бүрэлдхүүний нэг нь эрүүл мэндийн боловсрол юм.

Боловсрол гэдэг нь хувь хүний хөгжил, төлөвшил, хүмүүжлийн цогц бөгөөд энэ нь гэр бүлийн орчин, албан болон албан бус боловсролоор дамжин олж авч буй мэдлэг, чадвар, дадал, туршлага үнэт зүйлийн тухай нэгдмэл ойлголт юм. Нөгөө талаар боловсрол нь хүнийг бий болгох, бүтээх, хөгжүүлэх, төлөвших үйл явцыг хурдасгах, хөнгөвчлөх, чиглүүлэх үүрэг бүхий боловсролыг тогтолцооноос шууд хамаардаг. Хувь хүний хувьд урлагийн, спортын, сэтгэл зүйн, инженерийн, эдийн засгийн гэх мэтээр төрөлжсөн боловсрол эзэмшдэг хэдий ч хамгийн чухал нь эрүүл мэндийн буюу хүн өөрийгөө танин мэдэж хоол хүнсээ тохируулж хэрэглэх, ажил амралтаа зохицуулах, буруу зуршлаас зайлсхийх зэрэг наад захын эрүүл мэндийн боловсрол чухал юм. Хүний эрүүл мэнд, өвчин эмгэгийн эрсдэл, шалтгааны дийлэнх нь урьдчилан сэргийлж болох тухайн хүний амьдралын хэв маяг, зан үйл, дадлаас хамаардаг тул эрүүл мэндийн боловсрол зайлшгүй шаардлагатай. Эрүүл мэндийн боловсрол нь ард иргэдэд орчны эрүүл мэнд, биеийн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэнд, сэтгэл, оюун санаа, бие бялдрын эрүүл мэндийн мэдлэгийг олгож, хувь хүмүүст эрүүл мэндээ хэрхэн дэмжих, хадгалах, засах арга барилд сурах зарчмыг танин мэдэх, төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй.

Хүн амын эрүүл мэндийг нийтийн эрүүл мэндийн тусламж, ялангуяа иргэдийн эрүүл мэндийн боловсролыг системтэйгээр, цогцоор нь өөрчлөхгүйгээр сайжруулах боломжгүй бөгөөд үүний улмаас хүн амын дундах өвчлөл тасралтгүй нэмэгдэж эрүүл мэндийн салбарын дийлэнх нь эмнэлгийн тусламж буюу хэвтэн эмчлүүлэхэд чиглэж байна. Үүнийг өөрчлөхийн тулд хувь хүн, гэр бүл, хамт олонд чиглэсэн мөн бүх шатны боловсролын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоонд тулгуурлан эрүүл мэндийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх нь чухал учраас “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний үйл ажиллагааны стратегид тодорхой зорилтуудыг тусгасан.



ЗОРИЛТ

Инноваци, дижитал технологийн дэвшлийг ашиглан сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалт, бүртгэл мэдээллийн тогтолцоог бүрдүүлж хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, зөвлөн туслах цахим мэдлэгийн сан, цахим үйлчилгээг нэвтрүүлэх:

- Суралцагчдын эрүүл мэндийн хяналт, тандалт, бүртгэл мэдээллийн тогтолцоог бүрдүүлэн эрүүл мэндийн үзлэг, эмгэгийг бие бялдрын хөгжил, насны бүлэгт тохируулан явуулах эрх зүйн орчинг бий болгох, хэрэгжүүлэх
- Бүх шатны сургалтын хөтөлбөр дэхь эрүүл мэнд, биеийн тамир зэрэг хичээлийн агуулга, арга зүйг шинэчлэх, сургалтын багийг чадавхжуулах замаар эрүүл мэндийн боловсрол бүхий ирээдүйг бий болгох
- Нийтийн эрүүл мэндийн хүртээмжтэй, оновчтой, шинжлэх ухаанч эрүүл мэндийн мэдлэг мэдээллийг түргэн, шуурхай, нэг цэгээс хялбар аргаар хүлээн авах боломж бүхий семантинк текст, текстийг аудио болгон хөрвүүлэх технологид суурилсан “Мэдлэгийн сан” дэд системийг хөгжүүлэх
- Иргэдийн оролцоонд тулгуурлан өөрийгөө үнэлэх, дүгнэх эцэг эх болон суралцагч, багшийг хамруулсан өргөн хэрэглээний эрүүл мэндийн апп-н хөгжүүлэн судалгаанд суурилсан мэдлэг, дадлыг бий болгоход холбогдох талуудтай хамтран ажиллах

“Мэдлэгийн сан” нь эрүүл мэндийн боловсрол олгох, мэдлэг түгээх үндсэн зорилготой бөгөөд эрүүл мэндийн мэдлэгийг системтэйгээр нэгтгэн хадгалж, иргэд өөрсдийн сонирхсон сэдвээрээ хүссэн цагтаа хүлээн авах технологийн шийдэлд суурилсан шинэ санаачилга юм.

Эрүүл мэндийн мэдлэгийн сангаас зөвлөгөө мэдээлэл хүлээн авах мэдээллийн жагсаалтаа сонгоно уу

Үндсэн сэдэв
Шууд

Мэдээлэл хүлээн авагчийн насны бүлэг
Хүүхэд

Дэд Сэдэв
Хүүхдийн шүүд | Бага насны хүүхдийн шүүд | Амьд настны шүүд

Мэдээлэл хүлээн авах суваг
 Facebook-чат болоор
 Иxкэйлээр
 Утасны мессежээр

Утасны мессежээр
99101010 | код авах

Эрүүл ирээдүйг бий болгохын тулд Боловсролын салбарын удирдлагуудтай цуврал уулзалт зохион байгуулж

1. Бүх шатны хөтөлбөр дэхь эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, сэтгэц болон зан үйлийн хичээлд цогц шинэчлэл хийх,
2. Сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалт тогтолцоог бий болгох,
3. Сургуулийн хүүхэд хамгааллын багийг чадавхжуулах чиглэлд хамтран ажиллаж, тодорхой шийдэлд хүрээд байна.

**СУРГУУЛЬД СУУРИЛСАН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯНАЛТ,
ТАНДАЛТЫН
БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН
ТОГТОЛЦОО:**

ШИЙДЭЛ:


- Туршилтын төсөл 2 аймаг, 1 дүүрэгт хэрэгжсэн тул үндэсний хэмжээнд хэрэгжих боломж бүрдсэн
- Сурагчийн бэлтгэгдсэн байдлын үнэлгээтэй Эрүүл мэндийн үзлэгийг хамтран зохион байгуулах
- Боловсролын салбарын гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдах

ЕБС
ЭЛСЭХ




**ЭРҮҮЛ МЭНДИЙН
БОЛОВСРОЛ**

ХӨТӨЛБӨРИЙН ШИНЭЧЛЭЛ



ГУРАВ **УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ БНСУ-ЫН ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙН ДЭД ДАРГЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх БНСУ-ын Үндэсний Ассамблейн дэд дарга Ким Ён Жү-г 2023 оны хоёрдугаар сарын 15-ны өдөр хүлээн авч уулзав. Хатагтай Ким Ён Жү Монгол Улс, БНСУ-ын харилцаа, хамтын ажиллагаа, ялангуяа хууль тогтоох байгууллага хоорондын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байгааг Ерөнхийлөгч тэмдэглэв.

Хоёр улс НҮБ болон Олон улс, бүс нутгийн түвшинд амжилттай хамтран ажиллаж байгааг хэлээд, БНСУ-ын Ерөнхийлөгч Юн Сог Ёль-д мэндчилгээ дэвшүүлж байгааг уламжлахыг хүсэв.


Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг дэмжихээ БНСУ-ын Үндэсний Ассамблейн дэд дарга Ким Ён Жү илэрхийллээ. Энэ хүрээнд Солонгосын “Ногоон эмнэлэг”-тэй хамтран хүүхдийн эрүүл мэндийг дэмжих төсөл хэрэгжүүлж, хоол тэжээлийн дутагдал, амьсгалын замын өвчний эмгэгийн үеийн тусламжийг өргөжүүлэхийн зэрэгцээ монгол эмч нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулан мэргэшүүлэх чиглэлд холбогдох яам, эрүүл мэндийн байгууллагууд хамтран ажиллаж эхэллээ.

“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ЯПОН УЛСТАЙ ХАМТРАН ЗҮРХ, СУДАСНЫ ТӨВ БАЙГУУЛНА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сард Япон Улсад хийсэн айлчлалын мөрөөр эрүүл мэнд, анагаах ухааны салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг дэмжин, хоёр орны иргэдийн эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр Японы талтай идэвхтэй хамтран ажиллахаар боллоо. Энэ тухай Санамж бичигт талуудыг төлөөлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга А.Үйлстөгөлдөр, Япон Улсын “Токүшюүкай медикал групп”-ийн Ерөнхийлөгч Хигашиүэ Шиничи нар 2023 оны нэгдүгээр сарын 05-ны өдөр гарын үсэг зурлаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Улсын Гуравдугаар төв эмнэлгийг түшиглэн Зүрх, судасны төв байгуулах, тоног төхөөрөмжөөр хангах; Монгол Улсад оношилж чаддаггүй эмгэгүүдийг зөв оношилж, эмчилгээ хийх чиглэлээр



монгол эмч нарт мэргэжил эзэмшүүлэх, боловсон хүчин бэлтгэх; Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй зарим өвчнийг Япон Улсад оношлуулах, эмнэл зүйн тусламж авах, Япон Улсын нарийн мэргэжлийн эмч нар сургалт хийх зэргээр хамтран ажиллана хэмээн Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан онцоллоо.





ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МОНГОЛ УЛС ДАХЬ СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ ДР.СОКОРРО ЭСКАЛАНТЕГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан ДЭМБ-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгч Др. Сокорро Эскалантыг 2023 оны дөрөвдүгээр сарын 05-ны өдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтаар зөвлөх Т.Мөнхсайхан Др.Сокорро Эскалантед ДЭМБ-ыг төлөөлж Монгол Улсад суух Суурин төлөөлөгчөөр томилогдсон явдалд баяр хүргэж, Монгол Улс, ДЭМБ-ын үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, тэр дундаа хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд тус байгууллага үнэтэй хувь нэмэр оруулж ирснийг талархан дурдав.

Суурин төлөөлөгч Др. Сокорро Эскаланте “ДЭМБ-ын зүгээс улс, орнуудыг эмнэлэг шүтсэн тогтолцооноос илүүтэйгээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарч ажиллахыг зөвлөдөг. Энэ ч үүднээс миний бие танай сайхан эх оронд ирсэн цагаасаа эхлүүлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, эрхэмсэг Ноён У.Хүрэлсүх хүн амынхаа эрүүл мэндийг хамгаалах чиглэлд онцгой, өндөр ач холбогдол өгөн олон ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байгаа талаар сонссоор ирлээ. Тэр дундаа нийгмийн эрүүл мэндийн чиглэлээрх “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж эхэлснийг сонсоод талархан хүлээн авлаа. Бид бүх нийтийн эрүүл мэндийн төлөөх та бүхний үйл хэргийг дэмжин ажиллах болно” хэмээв.

ЯПОН УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, НОЁН КАЦУНОБУ КАТОТАЙ УУЛЗАЖ, САНАА СОЛИЛЦОО



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхий сайдын орон тооны бус зөвлөх, “Монгол-Японы Тогтвортой хөгжлийн нийгэмлэг” төрийн бус байгууллагын тэргүүн Б.Баярсайхан нар 2023 оны хоёрдугаар сарын 14-19-ний өдрүүдэд Япон улсад ажлын айлчлал хийлээ. Тус айлчлалаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Эрүүл монгол хүн” хөдөлгөөний Япон улстай хамтран эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эмнэлгийн засаглалыг хөгжүүлэх талаар Япон улсын Эрүүл мэндийн сайд, Ноён Кацунобу Катод бараалхаж, талууд санал солилцлоо.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД Л.ЭНХ-АМГАЛАНТАЙ УУЛЗАЖ, ЭРҮҮЛ ИРЭЭДҮЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ТАЛААР САНАА СОЛИЛЦОВ




Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний чухал бүрэлдэхүүн болох эрүүл мэндийн боловсрол ялангуяа бүх шатны боловсролын байгууллагын хөтөлбөрт уг асуудлыг хэрхэн тусгах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хамтран ажиллах чиглэлээр 2023 оны нэгдүгээр сарын 19-ны өдөр УИХ-ын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, БШУ-ны сайд Л.Энх-амгалан болон яамны удирдлагын багтай уулзаж, санал солилцлоо.

Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-амгалан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний чухал хэсэг нь хүүхэд залуус буюу эрүүл ирээдүйг төлөвшүүлэх бөгөөд энэ чиглэлд анхаарч, ялангуяа бүх шатны боловсролын хөтөлбөрийн шинэчлэл хийгдэж буй цаг

үе давхцаж байгаа тул хоорондоо санал солилцон оновчтойгоор тусган хамтран ажиллахыг холбогдох газар, хэлтсийн удирдлагын багуудад чиглэл өгч, бүх талаар хамтран ажиллана хэмээн онцоллоо.

ЕТГ-ын Эрүүл Монгол хүн төсөл, хөтөлбөр хариуцсан албан дарга О.Чимэдсүрэн “Сургуулид сууриласан эрүүл мэндийн хяналт, тандалтын тогтолцоо”-г бий болгон суралцагчдын эрүүл мэндийн нэгдсэн мэдээний сан үүсгэх, эмгэгийг эрт илрүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлийн төлөвлөлтийг танилцууллаа.



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ, БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТАЙ ХАМТАРСАН УУЛЗАЛТ ХИЙВ



Ерөнхийлөгчийн тамгын газрын “Эрүүл Монгол хүн” төсөл, хөтөлбөр хариуцсан албанаас 2023 оны хоёрдугаар сарын 13-ны өдөр Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ), Боловсролын ерөнхий газар (БЕГ)-тай хамтран бүх шатны боловсролын хөтөлбөр дэх эрүүл мэндийн хичээлийн агуулга, багшлах баг, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уулзалтад Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв,

Нийслэлийн боловсролын газар, дүүргүүдийн боловсролын хэлтсийн удирдлагууд оролцов.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан уулзалтыг нээн хэлсэн үгэндээ “Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй гурван тулгуурт үндэсний хөдөлгөөний нэг нь “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн бөгөөд иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар хүн амын дундах сэргийлж болох эмгэгийг бууруулахад бодлого чиглэж байна. Ялангуяа боловсролын бүх шатны байгууллагуудаар дамжуулан системтэйгээр СӨБ, ЕБС-ийн хөтөлбөр дэх эрүүл мэнд, бие бялдрын боловсролын хичээлийг чанаржуулах, багшлах багийг бэлтгэх, сургалтыг хүүхдийн нас, хүйс, физиологийн онцлогт нь тохируулан, системтэйгээр олгох нь чухал бөгөөд эрүүл мэндийн хяналт, тандалтын тогтолцоог судалгаанд суурилан хэрэгжүүлэх талаар танилцуулав.

Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир “Бид олон жил бодлогынхоо төвд дээрх хөтөлбөрөө тавьж ирснийг шинэчилж, хүүхдийг нэгт тавьж ажиллаж байна. Хүүхэд хэчнээн сурах чадвартай байгаад ходоод нь хоосон бол сайн сурахгүй. Хүүхэд ар гэртээ хүчирхийлэлд өртдөг бол бие, сэтгэцийн хувьд эрүүл байх боломжгүй. Эрүүл монгол хүүхэд, эрүүл монгол хүнийг бий болгоход цогцоор нь асуудлыг шийдэх нь чухал. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн энэ асуудлыг олон талаас нь харж, цогцоор нь шийдэхээр шинэ алхам болж байна” гэв.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ ЗХЗ САГСАН БӨМБӨГИЙН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙНХНЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Монголын 3х3 сагсан бөмбөгийн үндэсний шигшээ багийн тамирчид, багш, дасгалжуулагчийг 2023 оны дөрөвдүгээр сарын 07-ны өдөр хүлээн авч уулзлаа.

Сингапур Улсад зохион байгуулагдсан FIBA ЗХЗ сагсан бөмбөгийн 2023 оны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд эрэгтэй 24, эмэгтэй 18 баг өрсөлдсөнөөс Монгол Улсын үндэсний шигшээ эрэгтэй баг нэгдүгээр байр, эмэгтэй баг зургаадугаар байранд орсон юм. Монгол Улсын тамирчид багийн спортоор түүхэн амжилт гаргаж, Ази тивийн хошой аварга болсонд Монгол Улсын Ерөнхийлөгч баяр хүргэж, ард түмний нэрийн өмнөөс талархал илэрхийлэн сагсан бөмбөгийн үндэсний шигшээ багийн тамирчдын олимпын эрх авах, оноо цуглуулах тэмцээнүүдэд нь амжилт хүслээ.





МОНГОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АНХНЫ "МЕДЛИГ 2023" САГСАН БӨМБӨГИЙН ЛИГТ БАГ ТАМИРЧДЫН ХАМТААР ОРОЛЦОВ

Монголын эрүүл мэндийн салбарынхны дунд зохион байгуулагдаж буй "МедЛиг 2023" сагсан бөмбөгийн тэмцээнд 2023 оны дөрөвдүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спортын зөвлөх Т.Мөнхсайхан эмч, ажилчдаар багаа бүрдүүлэн тус лигт идэвх, санаачлагатай манлайлан оролцож, нийтийн биеийн тамир, спортыг олон нийтэд сурталчлан таниулах тэр дундаа эрүүл мэндийн салбарынхан өөрсдөөрөө үлгэрлэн нийгэмд спортоор хичээллэхийн ач тус, эрүүл зан үйлийг сурталчлах энэхүү лигийг зохион байгуулж байгаа явдалд талархал илэрхийлэн нийт баг тамирчдад амжилт хүсэж нээлтийн үг хэлэв. Тус тэмцээнд нийт 40 багийн



400 гаруй тамирчид оролцож байгаа бөгөөд Т.Мөнхсайхан ахлагчтай баг нээлтийн тоглолтыг хожлоор эхлүүллээ. Энэхүү тэмцээн нь 2 сар гаруй хугацаанд үргэлжлэх ба оролцож буй багууд хүчтэй, өрсөлдөөнтэй, ширүүхэн тоглолтуудыг үзүүлсээр байна.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛИЙН ХОЛБООДТОЙ САНАЛ СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ ХИЙВ



Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол Хүн" үндэсний хөдөлгөөний нэг гол бүрэлдэхүүн хэсэг нь нийтийн дунд идэвхтэй дасгал, хөдөлгөөн, эрүүл зан үйлийг бий болгох юм. Энэ ч үүднээс биеийн тамир, спортыг өдөр тутмынхаа үйл хэргээрээ сурталчлан, таниулж яваа 60 орчим мэргэжлийн холбоод, нийгэмлэгийн удирдах ажилтнуудад "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөний бодлого, зорилго чиглэлийг танилцуулж, санал солилцох уулзалтыг 2023 оны дөрөвдүгээр сарын 17-ны өдөр Төрийн ордонд зохион байгууллаа.





Уулзалтад Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, биеийн тамир, спортын чиглэлээрх төрийн болон төрийн бус мэргэжлийн холбоодууд, нийт 60 орчим төлөөлөл оролцлоо.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМЧ, АЖИЛЧИДАЙ ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ, ЯРИЛЦАГА ХИЙВ

Хан-Уул, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдын урилгаар Олон улсын эмч нарын баярыг угтсан “Эртэч эмч” өглөөний уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх, Анагаах ухааны доктор Т.Мөнхсайхан, Ерөнхийлөгчийн Тамгын газрын “Эрүүл Монгол хүн” төсөл, хөтөлбөр хариуцсан албаны дарга, доктор О.Чимэдсүрэн нар 2023 оны гуравдугаар сарын 29, 30-ний өдрүүдэд уулзалт,

ярилцлага хийв.

Олон улсын эмч нарын баярыг угтаж эмч нараа илүүтэй сонсох, тэдэнд тулгамдаж байгаа асуудлууд хийгээд Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрхэн хамтарч ажиллах чиглэлээр чөлөөт ярилцлага өрнүүллээ. Өглөөний уулзалтад дүүргүүдийн удирдлага, эмч, ажилчдын 100 орчим төлөөлөл оролцов.



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗУРГААН НАСТАЙ ХҮҮХДҮҮДИЙГ ЗҮРХНИЙ ИЛРҮҮЛЭГТ ХАМРУУЛАХ УУЛЗАЛТ, ТАНИЛЦУУЛГЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд зургаан настай хүүхдүүдийг зүрхний эмгэг илрүүлэгт хамруулах ажил өрнөж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хан-уул дүүргийн Засаг даргын Тамгын газар хамтран тус дүүргийн зургаан настай хүүхдүүдийг зүрхний эмгэг илрүүлэгт хамруулах ажлыг зохион байгуулж байна. Энэ хүрээнд Хан-Уул дүүргийн Төрийн өмчийн Ерөнхий боловсролын 23 сургуулийн 4777 зургаан настай хүүхдүүдийг зүрхний эмгэгийн илрүүлэгт хамруулахаар 52 болон 75 дугаар сургуулиудаас тус үйл ажиллагааг 2023 оны гуравдугаар сарын 17-ны өдрөөс эхлүүлэв. Зургаан настнуудын бие, бялдрын үнэлгээ болон зүрхний эмгэгийн илрүүлгийг өртөөчилсөн байдлаар зохион байгуулах ба эцэг, эх асран хамгаалагчидтай уулзаж, үйл ажиллагааны талаар танилцуулж, санал солилцлоо.

Зүрхний эмгэгийг илрүүлэх үйл ажиллагааг нь 2022 онд Увс, Архангай аймгуудад хэрэгжиж, 2800 орчим зургаан настай хүүхдүүдийг үзлэгт хамруулсан. Үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс 170 хүүхдэд зүрхний цахилгаан бичлэгээр өөрчлөлт илэрч, үүнээс 12 хүүхэд зүрхний мэс засал хийх шаардлагатай нь оношлогдсон байна. Эдгээр хүүхдүүд төрөлжсөн нарийн

мэргэжлийн эмнэлэгт тусламж үйлчилгээг авч, бүрэн эдгэрсэн. Уг илрүүлгийг Япон улсад мөрдөж буй зааврыг удирдамж болгон зүрхний эмгэгийн илрүүлгийг хийж байгаа бөгөөд Япон улсад 2012 онд хийгдсэн зүрхний илрүүлгийн судалгаагаар нийт хүүхдийн 3.3%-д зүрхний эмгэг илэрч, 0.99%-д эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай байв. Харин манай улсын хувьд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаануудын нэг зүрх судасны өвчлөл, нас баралтыг бууруулахад сургуульд суурилсан эрүүл мэндийн илрүүлгийг бага ангиас эхлэн зохион байгуулж, хүн амыг эрүүлжүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх нь зайлшгүй шаардлагатай байгаа талаар “Эрүүл Зүрх” үйл ажиллагааг зохион байгуулж буй хүүхдийн эмч, судлаач С.Энхцолмон хэллээ.

Үйл ажиллагааг нээж Ерөнхийлөгчийн эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан хэлсэн үгэндээ Эрүүл ирээдүйг бий болгохын тул юун түрүүн тэдний эрүүл мэндийг үнэлэх, эмгэгийг эрт илрүүлэх, эрүүл мэндийн тандалтын тогтолцоог бүрдүүлэх нь чухал. Иймд 6 настай сурагчдын эрүүл мэнд, ялангуяа зүрхний эмгэгийн илрүүлэгт хамруулан эрт сэргийлэх, хянах чиглэлд бид Хан-уул дүүргийн ЕБС-ийн 6 настанд сургуулийг түшиглэн ЭМТ, ӨЭМТ-тэй хамтран олон талт ажлууд хийнэ хэмээн онцлов.



“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД

■ ДӨРӨВ





“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН БАЯНХОНГОР АЙМАГТ

*Д.Мөнхсайхан,
Баянхонгор аймгийн Засаг дарга*

“

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар улс орон даяар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөнд Баянхонгорчууд бид нэгдсэн. Учир нь ахмад буурал, идэр залуус, ирээдүйн хойч үеийн эрхмийн эрхэм үнэт зүйл болох эрүүл хүн байж чадаж буй эсэхэд эдүгээ нэг дүн шинжилгээ хийж, эрсдэл байвал шийдэл гаргаж энэ цөөхөн үндэстнээ хамгаалах бодлого манайд үгүйлэгдэж байсан юм.


Үүнийг улсын тэргүүн маань олж харж, үндэсний хөдөлгөөн болгон өрнүүлсэнд баяртай байна. Баянхонгор аймгийн хувьд Эрүүл Монгол Хүн агуулгын хүрээнд архинд донтох эмгэгтэй иргэдийгээ эмчлэх, тэдний ар гэр, үр хүүхдэд элэг бүтэн, халуун дулаан аз жаргал бэлэглэх үүднээс “Жаргалтай амьдрал” төвийг 2020 оны намар байгуулж энэ оны 11 сарын байдлаар 560 дахь хүнээ хүлээн авч эмчилж байна. Аймагтаа сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний энэ төвийг байгуулан сэтгэцийн эмч, сэтгэл зүйч, гэр бүл судлаач, нийгмийн ажилтан зэрэг мэргэжлийн багийг томилон, гарах зардлыг орон нутгаас шийдвэрлэн ажиллаж байна. Энэ хугацаанд Согтууруулах ундааны сөрөг нөлөөллийг ухуулан таниулах, хувь хүний сэтгэл зүйтэй ажиллах, итгэл хүлээлгэх зэрэг олон талын цогц арга хэмжээг манай мэргэжлийн баг явуулсны үр дүнд дээрх иргэдийн 75 хувь нь өнөөдрийн байдлаар согтууруулах ундаа дахин хэрэглээгүй байна. Өнөөдрийн төвшинд дүгнэхэд 500 гэр бүл архины хамааралтай хэрүүл маргаангүй тайван амгалан болж, гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэрэг зөрчлийн тоо аймгийн хэмжээнд буурч байгааг дуулгахад таатай байна.

Саруул ухаантай, эрүүл хүнтэй байхад энэ Монгол улс маань үргэлж хөгжин дэвжинэ дээ.

БАЯНХОНГОР АЙМАГТ НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг сурталчлах, орон нутгийн онцлогийг тусгах, тэдний оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх зорилгоор Ерөнхийлөгчийн Тамгын газраас Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг 2022 оны 10 дугаар сарын 3-6-ны өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулав.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг үндсэн 4 бүрэлдэхүүн болох эрүүл зөв хооллолт, эрүүл зан үйл, нийтийн биеийн тамир, эрүүл мэндийн боловсролыг сурталчлах зорилгоор уг өдөрлөгт Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын Нэгдүгээр Төв эмнэлэг, Биеийн тамир, Спортын Улсын хороо, Спортын холбоод, Эрүүл мэндийн хөгжлийн зуун явуулын эмнэлэг, ШУТИС-ийн хоол судлалын баг бүхий нийт 80 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажиллалаа.



Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, 20 сумдын засаг дарга, Цагдаагийн газар, ЕБС-ийн захирлууд, Сумын эрүүл мэндийн төвийн дарга нар болон албан байгууллагуудын удирдлагын баг зэрэг 150 гаруй төлөөлөл, иргэд, олон нийтийн төлөөлөл нийт 450 орчим хүнийг хамруулан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг танилцуулан Эрүүл Баянхонгор аймаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэл, арга зам, иргэдийн оролцоо, саналыг сонсон хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулав.

Тус арга хэмжээний үеэр сурагчдын үдийн хоол хөтөлбөр, эрүүл зөв хооллолтын талаар танилцуулан сургуулийн захирлууд, эмч нарын баг, аймгийн удирдлагын багийн 60 гаруй төлөөллийг үдийн хоолны үзэсгэлэн, хоолны амталгаа, сургалт зэрэгт хамрууллаа. Аймгийн хүн амын дунд түгээмэл тохиолдож буй сэргийлж болох эмгэгийн эрсдэлт хүчин зүйлс, архи тамхины хэрэглээний өнөөгийн суурь үзүүлэлтийг тодорхойлох цогц судалгааг эхлүүлж, Эрүүл Баянхонгор, эрүүл сум, эрсдэлгүй өрх, эрүүл сургууль, эрүүл хамт олон зэрэг олон талт, зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэхээр ярилцан нээлттэй өдөрлөгийг амжилттай зохион байгуулав.





“Согтууруулах ундааны хэрэглээнээс татгалзаж сурцгаая”, “Таны хүүхэд хуруугаа хөхөж байна уу”, “Хүүхэд стресст өртдөг үү?”, “Сэтгэл гутрал”, “СЭМҮТ-ийн сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 24 цагийн зөвлөгөө мэдээлэл хүргэдэг 1800-2000 утас”, “Архинд донтох эмгэгийн өвөрмөц эмчилгээ-Алкобус-ДИЗ”, “Өсвөр үеийхний мансууруулах бодисын хэрэглээ” зэрэг 7 төрлийн 4800 ширхэг санамж, мэдээлэл тарааж өгчээ.

Эрүүл мэндийн төвийн 20 өрх, сумдын эрхлэгч эмч нар, нийгмийн ажилтнуудад салбар дундын сургалт зохион байгуулагдаж АУ-ны доктор Н.Алтанзул, “Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, стресс менежмент” АУМагистр С.Мөнхтуяа, “Архинд донтох эмгэгийн тухай ойлголт, тусламж үйлчилгээний орчин үеийн чиг хандлага”, Ж.Гантулга, “AUDIT сорилоор архины хэрэглээний түвшин тодорхойлох, арга” тус тус сэдвүүдээр илтгэж цэцэрлэг, сургууль, албан байгууллага, ажлын байранд урьдчилан сэргийлэх ажлыг яаж зохион байгуулж, тогтмол

үйл ажиллагаа явуулж байх талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллажээ.

Түүнчлэн эрүүл мэндийн төвийн 20 сумдын эрхлэгч, нийгмийн ажилтнуудад салбар дундын сургалтыг үргэлжлүүлэн Ж.Гантулга, “Сургалт: Архи согтууруулах ундааны хэрэглээг судлах арга зүй”, АУМагистр С.Мөнхтуяа, “Архины хэрэглээтэй хүнд эрсдэлийн түвшинд тохирсон зөвлөгөө өгөх”, Тэргүүлэх зэргийн их эмч Д.Баттөр, “АА, өөртөө туслах бүлгийн үйл ажиллагааны туршлага”, Жаргалтай амьдрал төвийн сэтгэл зүйч “Баянхонгор аймаг дахь архины хамааралтай хүмүүст үзүүлж буй тусламж үйлчилгээний туршлага” сургалт хийлээ.

Сумын иргэдийг халдварт бус өвчний эрсдэлийн гол шалтгаан архи, согтууруулах ундааны хэтрүүлэн хэрэглэхээс татгалзуулах, бууруулах улмаар артерийн даралт ихдэлт, зүрх судасны эмгэг, чихрийн шижингийн II хэлбэр, хавдрын хүндрэл зэрэг өвчин эмгэг үүсэх хүндрэлээс 60-80 хувиар сэргийлж болохыг зөвлөв. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь аймгийн ард иргэдэд, артерийн даралт, зүрх судасны өвчлөлийн эрсдэлийн үнэлгээг 54,





биеийн ерөнхий үзүүлэлт, биеийн жингийн илүүдлийг тодорхойлж зөвлөгөө өгсөн 62, эрүүл зөв хооллолтын зөвлөгөө 55, дасгал хөдөлгөөн, эрүүл зөв дадал, эрүүл амьдралын хэв маягыг хэвшүүлэх талаар зөвлөгөө 86 хүнд тус бүр мэдээлэл өгч, сургалт сурталчилгааны 7 төрлийн 250 ширхэг брошур, гарын авлага тараажээ.

Баянхонгор аймагт зохион байгуулагдсан нээлттэй өдөрлөгийн арга хэмжээнд үзэсгэлэн гаргаж шинэ ногооны шүүс, смүүти бэлтгэн амталгаа хийв. Өргөн хэрэглээний хоол хүнсэнд агуулагдах өөх тос, ханасан өөх тос, элсэн чихрийн агууламж болон хоолтой холбоотой зарим өвчний талаар биет үзүүлэн болон хялбаршуулсан үзүүлэн, холбогдох ном, гарын авлагыг байршуулж, иргэдэд зөвлөгөө өгөв.



Цэцэрлэг, сургуулийн хоолны үйлчилгээнд ялгаатай байх үйлчилгээг харуулсан 10 гаран үзүүлэн, өргөн хэрэглээний нэг удаагийн сервинг хэмжээ ба илчлэгийн үзүүлэлт бүхий 15 хоолны модел дэлгэн харуулав.



1500 төгрөгийн төсөвт багтах 5 өдрийн иж бүрдэл хоолны үзэсгэлэн сонирхолтой байсан бөгөөд мягмар гаригийн хоолоор зочдод үйлчилсэн бөгөөд 1-5 дугаар ангийн хүүхдийн хувьд хоол ямар түвшинд байж болох талаар мэдээлэл хүргэж чадсан нь гол үр дүн юм.

Тус өдөрлөгийн хүрээнд Хөл бөмбөгийн "Грассрүүтс" сургалт, хөл бөмбөгийн тэмцээн, Сагсан бөмбөгийн 3x3 сонирхогчдын тэмцээн, идэвхтэй хөдөлгөөний "Флаш моб" зэргээс гадна сумын арга зүйч нарын сургалт зохион байгуулав. Эдгээр арга хэмжээнд нийт 489 хүн хамрагдав.



Тус өдөрлөгийн хүрээнд хөл бөмбөгийн фестивальд 80 хүүхэд, сагсан бөмбөгийн 3x3 сонирхогчдын тэмцээнд 150 тамирчин, идэвхтэй хөдөлгөөний флаш моб-д 300 гаруй иргэд оролцжээ.




СУРГАЛТ

1. Хөл бөмбөгийн “Грассруүтс” сургалт: Баянхонгор аймгийн 20 багш, 120 хүүхэд оролцов
2. Сумын биеийн тамирын арга зүйч нарын сургалт: Баянхонгор аймгийн 19 сумын биеийн тамирын арга зүйч хамрагдав



Үзлэгт хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр илэрхийлэв



Улсын нэгдүгээр төв эмнэлэг 9 чиглэлээр лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ, 5 чиглэлээр дэмжин туслах үйлчилгээ үзүүлэв. Дээрх хугацаанд давхардсан тоогоор 650 хүнд үзлэг оношилгоо хийсэн байна. Бөөрний хавдар-2, Элэгний хавдар-2, ходоодны хавдар 1 хүнд шинээр оношлогдсон бол баруун хөлийн артер судас бөглөрсөн-1, зүүн талын гүрээний венийн судасны бөглөрөл -1 тус тус оношлон УНТЭ рүү яаралтай шилжүүлээ.



Баянхонгор аймгийн иргэдэд “Хөгжлийн зуун” ТББ нарийн мэргэжлийн эмч нарын /Зүрх, дүрслэл оношилгоо, шүд/ үзлэг, оношилгоо хийв. Тус үзлэгт нийт 346 иргэн хамрагдав.

Шүдний үзлэгийн хүрээнд нийт 124 хүнд үзлэг хийснээс Шүдний өнгөц цоорол ихэнх хувийг эзэлж байна.

Үзлэг оношилгоогоор хэвлийн эхо, Зүрхний цахилгаан бичлэг 284 хүнд хийхэд Зүрхний томрол, таргалалт хэм алдалт, Бамбай булчирхайн өөрчлөлттэй хүмүүс их байв.



“6 настай хүүхдийн зүрхний эмгэг илрүүлэг, хяналт” – төслийн бэлтгэл ба сургалт үзлэгийн үеэр



“Эрүүл мэндийг дэмжигч сургууль”, сургуулийн орчны эрүүл ахуй сургалт зохион байгуулав.

Баянхонгор аймгийн ЕБС-ийн нийт 60 захирал, нийгмийн ажилтанд “Эрүүл мэндийг дэмжигч сургууль, Сургуулийн орчны эрүүл ахуйн талаар сургалт хийв.

Мөн ЕБС-ийн орчны эрүүл ахуй, аюулгүй байдал, хоол зүйн талаар 7 бүлэг бүхий 76 асуулттай судалгааг авч дүн шинжилгээ хийж байна.





“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” НАЛАЙХ ДҮҮРЭГТ

Л.Байгал

Налайх дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, “Хүнсний хувьсгал” Тэрбум” мод хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, иргэдэд таниулах хүрээнд “Эрүүл Налайх” судалгааны интервенцийг хэрэгжүүлэхээр боллоо. Энэхүү судалгаа нь Налайх дүүрэгт ямар өвчин зонхилж байгааг, урьдчилан сэргийлэлтийг хэрхэн хийснээр дээрхи судалгааны дүнд гарсан өвчнүүдээс урьдчилан сэргийлж болох, дундаж наслалтыг хэрхэн уртасгаж болох вэ гэдэг асуултын хариуг гаргаж хийх ажлын аргыг тогтооход орших юм. Энэ ажлын хүрээнд “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний ажлын албанд хүсэлт гарган “Эрүүл Налайхчууд” дэд хөтөлбөрийг (интервенц) хэрэгжүүлэхээр Ерөнхийлөгчийн Тамгийн Газар үндэсний хөдөлгөөний багт хандан хүсэлт гарган “Эрүүл эмнэлгийн ажилтан”, “Эрүүл эр хүн”, “Эрүүл залуус” дэд хөтөлбөрөөр 2022 оны 10 дугаар сарын 18-наас эхлүүлэн хүн амд эрсдлийн үнэлгээ хийж 1000 гаруй хүнийг хамруулаад байна. Үүнд:

- “Эрүүл эр хүн” 500 иргэн
- “Эрүүл эмнэлгийн ажилчид” (Эрүүл мэндийн төв, Өрхийн эмнэлэг) 200 ажилчид
- “Эрүүл оюутан” 200 гаруй оюутан (Монгол-Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургууль, Налайх дүүрэг дэх Алтан гадаст одонт Политехникийн коллеж)

Цаашдаа 45-аас дээш насны тодорхой хүмүүст нас, хүйс, ажлын байр, амьдралын орчиноос шалтгаалан сонголт хийн судалгаа хийхээр төлөвлөж байна. Үүний үр дүнд Налайх дүүргийн иргэдийн дундах өвчлөлийн бүтэц гарч ирэх ба түүнээс үндэслээд “Эрүүл Налайхчууд” интервенцийг боловсруулж санхүүжилтийг олон 2023 онд тухайн өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, хамгаалах, оношлох, эмчлэх зорилго бүхий хөтөлбөр гарган ажиллахаар төлөвлөж байна. Энэхүү зорилтод бүлгийн хүн амд эрүүл мэндийн эрсдлийн түргэвчилсэн үнэлгээг хийх комиссыг байгуулан төлөвлөгөөг боловсруулаад ажиллах нь илүү үр дүнтэй бөгөөд үнэлгээнд хамрагдсан хүмүүсээс архи, тамхины хэрэглээ, хоол хүнсний дэглэм мөрдөлт, зөв хооллолт, хөдөлгөөний эрчмийг асуумж судалгаагаар, биеийн жингийн индекс, артерийн даралт, амин үзүүлэлтийг үзлэгээр, цусан дахь сахар болон триглицеридийн хэмжээг лабораторийн аргаар судлаад эхний үнэлгээг хийж байна. Нэгэнт судалгаан дээр үндэслэн хийж байгаа болохоор Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” хөдөлгөөний хүрээнд “Эрүүл Налайхчууд” түүний дотор “Эрүүл эмнэлгийн ажилчид”, “Эрүүл оюутан”, “Эрүүл эр хүн” дэд хөтөлбөр нотолгоонд суурилсан бодит судалгаа бүхий үр дүнтэй ажил болно гэдэгт итгэлтэй байна. Энэхүү ажлыг 2023, 2024 онд хэрэгжүүлж үр дүнг тооцох болно.

“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН -НАЛАЙХ ДҮҮРЭГТ

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх суурь судалгааг Налайх дүүргээс эхлүүлж байна. Улсын хэмжээнд жишиг болох тус судалгааг “Ерөнхийлөгчийн зөвлөх АУ-ны доктор Т.Мөнхсайхан, ажлын хэсгийн ахлагч О.Чимэдцэрэн нарын удирдлага дүүргийн эрүүл мэндийн төвийн албан хаагчид оролцон гүйцэтгэв.

Тус ажлын хүрээнд эрүүл эмнэлгийн ажилчид, “Эрүүл залуу үе”-“Эрүүл оюутан”, “Эрүүл эр хүн” гэсэн чиглэлд цогц судалгаа хийгдэж эрэгтэй-935, эмэгтэй-798, эмнэлгийн ажилчид-241 хүн, цэргийн насны эрчүүд-495, Оюутан-265 хүнийг үзлэг оношлогоонд хамруулав.



Эрүүл оюутан оролцоо ба шийдэл хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулав



“Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөний үзэл баримтлал, зарчим, хэрэгжих арга зам, хүрэх үр дүнг түгээн дэлгэрүүлэх, иргэний нийгмийн байгууллага, мэргэжилтэн, судлаачид, зорилтод бүлгийн оролцоог хангах тэдний санал бодлыг тусгах зорилготой ЭРҮҮЛ ОЮУТАН-ОРОЛЦОО БА ШИЙДЭЛ сэдэвт хэлэлцүүлэг, парламентийн мэтгэлцээний тэмцээн 2022 оны 11 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд Монгол Улсын Их Сургуультай хамтран зохион байгуулав. Хэлэлцүүлэгт 13 их дээд сургуулийн төлөөлөл 64 багийн 128 мэтгэлцэгч найман хэсэгт хуваагдан мэтгэлцлээ. Тус хэлэлцүүлэг нь Эрүүл зөв хооллолт, эрүүл зан үйл, нийтийн биеийн тамир, эрүүл мэндийн боловсрол дөрвөн салбар хуралдаан бүхий хэлэлцүүлэг, сургалтад нийт 140 гаруй оюутан, залуус оролцож өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж, санал санаачилга гарган идэвхтэй оролцлоо.





Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газраас хэрэгжүүлэхээр зорьж буй “Эрүүл оюутан” дэд хөтөлбөрийг боловсруулахад шаардлагатай оюутнуудын эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх суурь судалгааг төр болон хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд, МСҮТ, коллежийн 3200 оюутнаас авах зорилт тавин ажиллаж өнгөрсөн 7 хоногт төрийн өмчийн 4 сургуулийн 987 оюутан, 3 хувийн их, дээд сургуулийн 612 оюутан, 2 коллежийн 172 оюутан нийт 1771 оюутныг хамруулан ажиллаж байна.

Оюутны эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийн судалгаа хийв



Их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт Эрүүл мэндийн талаарх агуулгын судалсан тойм судалгаа хийгдлээ



“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжих эрүүл оюутан хөтөлбөрийн суурь судалгааны нэг болох Их, дээд сургууль, МСҮТ, коллежийн сургалтын хөтөлбөрт эрүүл мэнд, эрүүл зан үйлийн талаарх агуулга тусгагдсан эсэх талаар тойм судалгааг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын хэмжээнд нийт 67 их, дээд сургуульд 148 954 оюутан, 76 МСҮТ, коллежид 42 594 оюутан залуус суралцаж байна. Тус судалгааг тэдгээрийн төлөөлөл 20 гаруй сургуулийг хамруулан хийв. Судалгааны үр дүнгээр Монгол Улсын хэмжээнд нийт судалгаанд хамрагдсан их, дээд сургуульд эрүүл мэнд, эрүүл зан үйлийн талаарх мэдлэг олгох хичээл нэгдсэн нэг стандартаар сургалтын хөтөлбөрт тусгагдаагүй. Төрийн өмчийн их сургуулиуд оюутан залуусын эрүүл мэндэд анхаарч тогтмол арга хэмжээ, үзлэг, оношилгоонд хамруулдаг бол хувийн хэвшлийн их, дээд сургуулиудад энэ байдал дутагдалтай байна. Оюутнуудын сонгон суралцаж буй мэргэжлээс шалтгаалан эрүүл мэндийн холбогдолтой хичээлүүдийг сургалтын хөтөлбөрт тусгасан байна. Жишээ нь: СУИС-ийн дуулаачийн ангийн оюутан “Хоолойн эрүүл ахуй” хичээлийг заавал судлах шаардлагатай бөгөөд мэргэжлийн суурь хичээл бол ШУТИС-д инженерээр суралцаж буй оюутан “Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал” хичээлийг заавал судлахаар байна.

МСҮТ, коллежид “Эрүүл мэнд” гэсэн албан ёсны нэршлээр бүх суралцагч нарт хичээл ордог бөгөөд тус хичээлийн агуулгын хувьд Хувийн болон орчны эрүүл мэнд, Хооллолт, хөдөлгөөн, Сэтгэцийн эрүүл мэнд, Хорт зуршил, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендерт суурилсан хүчирхийлэл зэрэг ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн агуулгатай адил байна.

Эрсдэлт хүчин зүйлс	Эрэгтэй		Эмэгтэй		Нийт	
	n	%	n	%	n	%
Согтууруулах ундаа хэрэглэх давтамж						
Хэрэглэдэггүй	378	88.9%	171	95.0%	549	90.7%
Сар өнөөдөр 1 удаа	34	8.0%	5	2.8%	39	6.4%
Сард 2-4 удаа	10	2.4%	2	1.1%	12	2.0%
Долоо хоногт 2-3 удаа	1	0.2%	1	0.6%	2	0.3%
Долоо хоногт 4+ удаа	2	0.5%	1	0.6%	3	0.5%
Тамхины хэрэглээ						
Татдаггүй	606	56.3%	292	92.7%	900	64.6%
Татдаг	471	43.7%	23	7.3%	494	35.4%
Хөдөлгөөний идэвх						
Хөдөлгөөний хомсдолтой	485	44.9%	186	59.0%	671	48.1%
Хөдөлгөөний идэвхтэй	594	55.1%	129	41.0%	723	51.9%
Гадуур хооллох давтамж						
Өдөр бүр	11	2.6%	13	7.2%	24	4.0%
5-6 өдөр	11	2.6%	13	7.2%	24	4.0%
3-4 өдөр	47	11.1%	18	10.0%	65	10.7%
1-2 өдөр	199	46.8%	80	44.4%	279	46.1%
Огт гадуур хооллодоггүй	157	36.9%	56	31.1%	213	35.2%
Нойрны чанар						
Сайн (0 оноо)	18	7.7%	9	8.0%	27	7.8%
Дунд (1-7 оноо)	137	58.8%	60	53.6%	197	57.1%
Муу (8-14 оноо)	71	30.5%	36	32.1%	107	31.0%
Маш муу (15-21 оноо)	7	3.0%	7	6.3%	14	4.1%
Хооллолтын байдал						
Эрүүл хооллолттой	122	28.7%	48	26.7%	170	28.1%
Эрүүл бус хооллолттой	303	71.3%	132	73.3%	435	71.9%

НАМАЙГ АЛГАС НӨЛӨӨЛЛИЙН АЯН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Намайг алгас” ухуулга, нөлөөллийн аяныг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд аяны брэндиг, стратегийг боловсруулж, олон нийтийн дундах архины өргөн хэрэглээг бууруулах, зохисгүй хэрэглээг буруутгах, зөв хандлага, сонголт, шинэ соёлыг төлөвшүүлэх, дэмжихэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны 28 ажил, арга хэмжээг төлөвлөн, зохион байгууллаа.

Аяны явцад хорт зуршлаас ангид шинэ үеийг төлөвшүүлэх, бүх нийтэд хэрэглээний зөв хандлага, соёл, сонголтыг уриалах, сурталчлан таниулах зорилготой үндсэн 88 видео шторк, 36 зурагт постерыг мэргэжлийн байгууллагуудаар бүтээлгэн, Ажлын хэсгээс 54 дэмжих видеог бэлтгэн олон нийтэд хүргэжээ.

Бэлтгэсэн видео контент, мэдээ, мэдээллүүдийг төв, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийн 130, худалдаа, үзвэр үйлчилгээний 214, нийт 344 сурталчилгааны лед дэлгэцээр нийтийн орон сууцны 900 лифт, 42 телевиз, 30 фм радиогоор тус тус түгээж, автобусны буудал болон автозам дагуу 143, бусад байршилд 38, нийт 181 мэдээллийн самбарт “Намайг алгас” сурталчилгаа, мэдээллийн постерыг байршуулав.

Иргэдийг соён гэгээрүүлэх, идэвхжүүлэх зорилгоор уулзалт, өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг давхардсан тоогоор 609 удаа зохион байгуулж, арга хэмжээний үндсэн агуулгыг таниулсан тараах материалыг 30.000 ширхэг хэвлэн төв, орон нутгийн худалгаа үйлчилгээний газар болон иргэд олноор цугладаг цэгүүдэд тараав.

Хамт олон, найз нөхдийн дундах архидалт, тэмдэглэлт өдрүүдийн архи согтууруулах ундааны хэт их хэрэглээг шүүмжилсэн, буруу үзэгдэл үйл явдлаас залуу үеийг татгалзуулж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хосууд гэр бүлдээ цаг зарцуулахад уриалсан 2 дууг бүтээн иргэд, олон нийтийн хүртээл болгов.

“Юнивишн”, “ДДИШ” телевизийн 400.000 хэрэглэгч айл, өрхөд “Намайг алгас” аяны сурталчилгааны баннер, “Скайтел”, “Жи Мобайль” үүрэн холбооны 1.475.251 хэрэглэгчийн дуудлагын аянд зохисгүй хэрэглээнээс татгалзах уриалга бүхий шторкийг байршуулах боломжийг бүрдүүлж, хамтран ажиллав.





Уг аяныг сурталчлах өдөрлөгийг улсын томоохон их, дээд сургуулийн төлөөлөл 1200 гаруй оюутан, залуусыг хамруулан энэ оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “ЮЖ Арина” цогцолборт зохион байгуулж, хэвлэл, мэдээллийн 23 телевиз, сайтаар иргэд, олон нийтэд түгээв.

Ухуулга, нөлөөллийн арга хэмжээний үр дүнд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт дуудлага мэдээлэл өмнөх сарын мөн үетэй харьцуулахад 1044, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчил гаргасан гэх дуудлага мэдээлэл 337 нэгжээр тус тус буурсан эерэг үзүүлэлт гаргав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас ЦЕГ-тай хамтран зохион байгуулсан мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд нийт 188 мэдээлэл бэлтгэн цахим орчинд түгээсэн нь давхардсан тоогоор 1.437.228 хүнд таалагдаж,

4.326.623 хүн бусадтай хуваалцаж, 402.332 хүн эерэг сэтгэгдэл илэрхийлж, 67.060.623 хүнд хүрсэн байна.

Монголын маркетингийн холбоо, “Unread” төрийн бус байгууллага хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг нийгмийн шилдэг төсөл шалгаруулах “Unread awards”-ын “Шилдэг санал, санаачилга төрөл”-д энэхүү ухуулга, нөлөөллийн аян хэвлэл, мэдээллийн байгууллагууд болон олон нийтийн цахим санал асуулгаар тэргүүн байр эзэлж, олон нийтийн талархлыг хүлээсэн үр дүнтэй ажил болсныг танилцуулъя.



“ЦАГ ГАРГАЯ” АЯН



“Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Цаг гаргая” аян нь бие бялдрын боловсролтой, идэвхтэй амьдралын хэвшилтэй эрүүл монгол хүний тоог нэмэгдүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн бүр өөрийн эрүүл мэндээ хайрлах, өөртөө цаг гаргахыг нийгэмд уриалж олон нийтэд таниулан сурталчлах, уриалах, агуулгыг илэрхийлсэн аян юм.

“ЦАГ ГАРГАЯ” АЯНЫ СТРАТЕГИ




- Хөдөлгөөний хомсдол, биеийн илүүдэл жингээс үүдсэн өвчлөл, үүдэн гарч буй сөрөг нөлөөлөл үр дагаврыг олон нийтэд таниулах замаар, дасгал хөдөлгөөнд уриалах, оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх
- Социал медиа платформ дээр контент маркетингийн ажлуудыг хэрэгжүүлэхээс гадна, нийт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, үйлдэл үр дүнд илүү төвлөрөх
- Залуу үеийг бие бялдрын боловсролтой, өөрт тохирсон дасгал хөдөлгөөнийг тогтмол хийх, эрүүл амьдралын хэв маягт уриалах
- Өөрийн эрүүл мэндээ хайрлах, өөртөө цаг гаргахыг нөлөөлөгч болон, идэвхтэй амьдралын хэвшилтэй хүмүүс, холбоод клубээр дамжуулан үлгэрлэж уриалах

“ЦАГ ГАРГАЯ” АЯНЫ ҮГНИЙ ТАЙЛБАР УТГА




“ЦАГ ГАРГАЯ” АЯНЫ ХҮРЭЭНД

Инфографик постер /ээрэг/



Инфографик постер /сөрөг/







МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



САР ШИНИЙН БАЯРЫГ УГТАН ЗОХИСТОЙ ХООЛЛОЛТ, ЭРҮҮЛ ЗАН ҮЙЛ, ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨНД ОЛОН НИЙТИЙГ УРИАЛАХ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

“Үзэсгэлэнт” болгогч хэмээн Туулай жилийн Сар шинийн баярыг угтан баярын үеийн согтууруулах ундааны хэтрүүлэн хэрэглээг бууруулах зорилгоор цахим орчинд иргэд, олон нийтэд зөв мэдээлэл олгох нөлөөллийн ажлыг 2023 оны 02 дүгээр сарын 11-ний өдрөөс 02 дугаар сарын 21-ний өдрийг хүртэл нийт 10 хоногийн хугацаанд дижитал медиа сувгийг ашиглан зохион байгуулав. Дээрх ажлын хүрээнд “Эрүүл Монгол хүн” албан ёсны фейсбүүк хуудсанд байршуулсан контентууд давхардсан тоогоор нийт 5.089.516 хүнд хүрчээ. Сар шинийн баярын үеийн архины зохистой хэрэглээ, зөв зохистой хооллолт, үл зохицох болон зохицох хоол хүнсний талаар мэргэжилтнүүдийн судалгаанд суурилсан зөвлөгөө, мэдээллүүдийг видео болон фото, постер хэлбэрээр нийгмийн сүлжээнд түгээв. Мөн зөв, зохистой хоол хүнсний гарын авлагыг бэлтгэн олон нийтийн сүлжээнд түгээж, иргэдийг үйлдэлд уриалсан ажлуудыг зохион байгуулав.







Ерөнхийлөгчийн Тамгын Газрын
"Эрүүл Монгол хүн" төсөл, хөтөлбөр хариуцсан алба

☎ 11-26 29 91

🌐 www.eruulmongolhun.mn

📘 Эрүүл Монгол хүн хөдөлгөөн